



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
2025 ОНЫ НАМРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАН

2025 ОНЫ 11 ДҮГЭЭР САРЫН 19-НИЙ ӨДӨР, ЛХАГВА ГАРАГ

ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ
БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААН

ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ ХЭЛТЭС

Та хуралдааны тэмдэглэлийн цахим хувьтай дараах
QR кодыг уншуулан танилцах боломжтой.

БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА

2025 оны 11 дүгээр сарын 19-ний өдөр, Лхагва гараг

Хуралдааны тэмдэглэлийн агуулга	1
Хуралдааны товч тэмдэглэл:	2-4
Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:	5-25

1. “Монгол Улсыг 2026-2030 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Засгийн газар 2025.10.30-ны өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг, санал, дүгнэлтээ Эдийн засгийн байнгын хороонд хүргүүлнэ/	5-25
---	------

**Монгол Улсын Их Хурлын 2025 оны намрын ээлжит чуулганы
Өргөдлийн байнгын хорооны 11 дүгээр сарын 19-ний өдөр
/Лхагва гараг/-ийн хуралдааны товч тэмдэглэл**

Өргөдлийн байнгын хорооны дарга О.Номинчимэг ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 25 гишүүнээс 13 гишүүн хүрэлцэн ирж, 52.0 хувийн ирцтэйгээр хуралдаан 15 цаг 30 минутад Төрийн ордны “Их эзэн Чингис хаан” танхимд эхлэв.

Томилолттой: Ж.Батсуурь, Б.Бат-Эрдэнэ, Х.Ганхуяг, Х.Жангабыл, П.Мөнхтулга;

Чөлөөтэй: Д.Рэгдэл;

Эмнэлгийн чөлөөтэй: С.Ганбаатар, М.Сарнай, Ч.Ундрам, Р.Эрдэнэбүрэн;

Тасалсан: Х.Баттулга, Б.Батцэцэг.

Нэг. “Монгол Улсыг 2026-2030 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Засгийн газар 2025.10.30-ны өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг, санал, дүгнэлтээ Эдийн засгийн байнгын хороонд хүргүүлнэ/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Боловсролын сайд П.Наранбаяр, Улсын Их Хурлын гишүүн, Эрүүл мэндийн сайд Ж.Чинбүрэн, Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Төрийн нарийн бичгийн дарга Л.Мөнхзул, мөн яамны Хөдөлмөр эрхлэлт, хөдөлмөрийн харилцааны газрын дарга Б.Алимаа, Нийгмийн халамжийн бодлогын газрын дарга Ю.Отгонбилэг, Нийгмийн даатгал, хуримтлалын сангийн бодлогын газрын дарга В.Рэнцэнханд, Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яамны Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Б.Даваацэрэн, мөн яамны Засгийн газрын тохируулагч агентлаг Биеийн тамир, спортын улсын хорооны даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Э.Билэг, Биеийн тамир, спортын бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга Д.Жаргалсайхан, Соёл, урлагийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга Н.Мөнхзул, Залуучуудын хөгжлийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга В.Батчимэг, Санхүү, хөрөнгө оруулалтын газрын дарга Ж.Отгонбат, Хөрөнгө оруулалтын хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч А.Амгаланзаяа, Цахим бодлого, статистик мэдээллийн хэлтсийн дарга Ч.Энхтуяа, Сайдын зөвлөх Ж.Эрхэмтөгс, Засгийн газрын Хэрэг эрхлэг газрын Салбарын бодлого зохицуулалтын газрын дарга Ш.Мөнхцэрэн, Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газрын Үнэлгээ,

мониторингийн газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Б.Золбоо, Эдийн засаг, хөгжлийн яамны Хөгжлийн нэгдсэн бодлого, төлөвлөлтийн газрын дарга Х.Сүрэнхорол, мөн яамны Макро эдийн засгийн бодлогын газрын дарга Л.Энх-Амгалан, Хөрөнгө оруулалтын бодлогын газрын дарга Б.Анар, мөн газрын Хөгжлийн төсөл, хөрөнгө оруулалтын удирдлагын хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Б.Төгөлдөр, Ногоон санхүүжилтийн бодлогын хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Б.Мөнх-Эрдэнэ, Шинжлэх ухаан, технологийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга Б.Мөнхтөр, Хөгжлийн нэгдсэн бодлого, төлөвлөлтийн газрын Салбар дундын бодлого, төлөвлөлтийн хэлтсийн дарга Б.Мөнгөнсүх, мөн хэлтсийн ахлах мэргэжилтэн З.Райымбек, Г.Отгонцэцэг, мөн газрын Тогтвортой хөгжил, нийгмийн бодлогын хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч П.Чандмань, Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайдын зөвлөх Б.Ганбат, Сангийн яамны Төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга М.Санжаадорж, мөн яамны Татварын бодлогын газрын дарга Б.Тэлмүүн, Хөгжлийн санхүүжилт, хөрөнгө оруулалтын газрын дарга Ж.Дэлгэржаргал, Боловсролын яамны Санхүү, хөрөнгө оруулалтын газрын дарга С.Должинсүрэн, мөн яамны Боловсролын ерөнхий газрын дарга Т.Ням-Очир, Боловсролын судалгааны үндэсний хүрээлэнгийн захирал П.Оюунаа, Дээд мэргэжлийн боловсролын бодлого, зохицуулалтын газрын дарга Н.Нарангэрэл, Ерөнхий боловсролын бодлого, зохицуулалтын газрын дарга М.Цогзолмаа, Цахим боловсрол, статистик, мэдээллийн хэлтсийн дарга Т.Бат-Эрдэнэ, Хоол үйлдвэрлэлийн хэлтсийн дарга Т.Түмэнжаргал, Сургуулийн өмнөх боловсролын хэлтсийн дарга Ж.Мягмар, Боловсролын зээлийн сангийн Дотоод зээл, тэтгэлэг, буцалтгүй тусламжийн хэлтсийн дарга Ц.Доржсүрэн, Бодлого төлөвлөлтийн газрын ахлах шинжээч Б.Бадамжав, Эрүүл мэндийн яамны Бодлого, төлөвлөлтийн газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Б.Туяа, мөн газрын ахлах шинжээч Э.Оюунсүрэн, Ш.Энхтуяа, Эрүүл мэндийн даатгалын Бодлого зохицуулалтын газрын дарга Д.Отгонбаатар, Нийгмийн эрүүл мэндийн бодлогын хэрэгжилтийн газрын дарга Б.Цэцэгсайхан, Эмнэлгийн тусламжийн бодлогын хэрэгжилтийн газрын дарга М.Наранпүрэв, Санхүү, даатгалын хэлтсийн дарга Л.Мөнхцэцэг, Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт зохицуулалтын газрын дарга Н.Эрдэнэбаяр, Эрүүл мэндийн хөгжлийн төвийн Их өгөгдөл, судалгааны албаны дарга Г.Дамба нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын газрын Өргөдлийн байнгын хорооны ажлын албаны зөвлөх Д.Наранцэцэг, референт С.Уянга, Г.Нямсүрэн, ажилтан Д.Оюун нар байлцав.

Тогтоолын төсөлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Л.Энхнасан, С.Зулпхар, А.Ариунзаяа, С.Эрдэнэболд, Б.Пунсалмаа, Ж.Галбадрах, Г.Лувсанжамц, Х.Баасанжаргал, О.Номинчимэг нарын тавьсан асуултад Боловсролын сайд П.Наранбаяр, Эрүүл мэндийн сайд Ж.Чинбүрэн, Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Төрийн нарийн бичгийн дарга Л.Мөнхзул, Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яамны Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Б.Даваацэрэн, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Салбарын бодлого зохицуулалтын газрын дарга Ш.Мөнхцэрэн, Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газрын Үнэлгээ, мониторингийн газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Б.Золбоо, Хөгжлийн нэгдсэн бодлого, төлөвлөлтийн газрын дарга Х.Сүрэнхорол, мөн яамны Макро эдийн засгийн бодлогын газрын дарга Л.Энх-Амгалан, Шинжлэх ухаан, технологийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга Б.Мөнхтөр, Сангийн яамны Төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга М.Санжаадорж, мөн яамны Хөгжлийн санхүүжилт, хөрөнгө оруулалтын газрын

дарга Ж.Дэлгэржаргал, Засгийн газрын Хэрэг эрхлэг газрын Салбарын бодлого зохицуулалтын газрын дарга Ш.Мөнхцэрэн, Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газрын Үнэлгээ, мониторингийн газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Б.Золбоо нар хариулж, тайлбар хийв.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Г.Лувсанжамц, Эдийн засгийн байнгын хорооны хуралдаанд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 17 цаг 00 минутад хэлэлцэж дуусав.

Байнгын хорооны хуралдаанаар 1 асуудал хэлэлцэв.

Хуралдаан 1 цаг 30 минут үргэлжилж, 25 гишүүнээс 13 гишүүн хүрэлцэн ирж, 52.0 хувийн ирцтэйгээр 17 цаг 00 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:
ӨРГӨДЛИЙН БАЙНГЫН
ХОРООНЫ ДАРГА

О.НОМИНЧИМЭГ

Тэмдэглэл хөтөлсөн:
ЧУУЛГАНЫ ХУРАЛДААНЫ
ХЭЛТСИЙН ШИНЖЭЭЧ

П.МЯДАГМАА

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2025 оны 11 дүгээр сарын 19-ний өдөр,
Лхагва гараг Төрийн ордон “Их эзэн Чингис хаан” танхим 10 цаг 18 минут

ӨРГӨДЛИЙН БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

О.Номинчимэг: Улсын Их Хурлын Өргөдлийн байнгын хорооны 2025 оны 11 дүгээр сарын 19-ний өдрийн хуралдаан нээхэд бэлэн болсон байна.

Байнгын хорооны эрхэм гишүүдийн энэ өдрийн амар амгаланг айлтгая. Ингээд ирц бүрдсэн тул хуралдаан нээснийг мэдэгдье.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 7.8-д заасны дагуу хуралдааны ирцийг танилцуулъя.

Манай байнгын хороо 25 гишүүнтэйгээс өнөөдөр ирсэн гишүүд 13 гишүүн буюу нийт гишүүдийн 52 хувь ирсэн байна. Хүрэлбаатарын Баасанжаргал гишүүн, Даваасамбуугийн Ганмаа гишүүн, Ганзоригийн Лувсанжамц гишүүн, Сүхбаатарын Эрдэнэбат гишүүн, Далайн Батбаяр гишүүн, Сонгобайн Замира гишүүн, Лувсанбямбаагийн Мөнхбаясгалан гишүүн, Бадамдоржийн Пунсалмаа гишүүн, Жанчивын Галбадрах гишүүн, Жаргалсайханы Золжаргал гишүүн. Цэндсүрэнгийн Мөнхтуяа гишүүн, Саруулсайханы Цэнгүүн гишүүн, Одсүрэнгийн Номинчимэг нар ирсэн байна аа.

Жамбын Батсуурь гишүүн орон нутагт томилолттой, Бат-Өлзийн Бат-Эрдэнэ гишүүн бас орон нутагт томилолттой. Сайнхүүгийн Ганбаатар гишүүн эмнэлгийн чөлөөтэй, Хассуурийн Ганхуяг, Хажикбэрийн Жангабыль гишүүд гадаад томилолттой, Пүрэвбаатарын Мөнхтулга гишүүн орон нутагт томилолттой, Дүгэрийн Рэгдэл гишүүн гадаадад томилолттой, Мягмардашийн Сарнай гишүүн, Чинбатын Ундрам гишүүд эмнэлгийн чөлөөтэй, Равжихын Эрдэнэбүрэн гишүүн бас эмнэлгийн чөлөөтэй байгаа юм байна аа.

Байнгын хорооны ирцийг танилцуулж дууслаа.

Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх асуудлыг танилцуулъя.

Өнөөдөр нэг асуудал хэлэлцэнэ. Монгол Улсын 2026-аас 2030 онд хөгжүүлэх 5 жилийн үндсэн чиглэл батлах тухай Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцэхээр байна аа. Хэлэлцэх асуудалтай холбоотойгоор саналтай гишүүн байна уу? Алга байна.

Хэлэлцэх асуудалдаа орохоос өмнө хариуцсан сайдыг оруулах хэрэгтэй байна. ЗГ-ыг төлөөлж хариулах сайдыг авчирч байж хуралдаанаа үргэлжлүүлье.

Өргөдлийн байнгын хороо яг иргэдээс ирж байгаа өргөдөл гомдол асуудлуудыг эрхлэх асуудлынхаа хүрээнд ялангуяа энэ намрын чуулганд иргэдээс

ирж байгаа өргөдөл нийтийн өргөдлийн системээр дамжуулж байгаа асуудлуудтай холбоотойгоор өргөн цар хүрээнд гишүүд ажилладаг. Энэ чиглэлээрээ бас ажлын хэсэг ч гэсэн байгуулаад ажиллаж байгаа учраас хөгжлийн төлөвлөгөө дээр яг энэ чиглэлийн асуудлууд байх юм бол зөвхөн нэг салбар гэлтгүй бас асуулт асуухаар байгаа. Тэгээд ядаж 1, 2 төлөөлөөд хариулчих ЗГ-ын гишүүн, сайд орж ирэхээр бас эхэлье гээд хүлээж байна. Бусад Байнгын хороо бас зэрэгцээд хуралдаж байгаа болохоор Байнгын хороодуудтай давхцаад сайд нар бас завгүй байх шиг байна. Тэгээд орж ирэх боломжтой сайдуудаа дуудаадхаарай.

Хэлэлцэх асуудалдаа орёе оо.

1. “Монгол Улсыг 2026-2030 онд хөгжүүлэх 5 жилийн үндсэн чиглэл батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн анхны хэлэлцүүлгийг хийж эхэлье ээ.

Тогтоолын төслийг хэлэлцэх эсэх хэлэлцүүлгийг Монгол Улсын Их Хурлын чуулганы 2025 оны 11 дүгээр сарын 13-ны өдрийн хуралдаанаар явуулж анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Эдийн засгийн байнгын хороонд болон бусад Байнгын хороодод шилжүүлсэн байгаа.

Тэгэхээр манай Өргөдлийн байнгын хороо бол өөрөө эрхлэх асуудлын хүрээнд буюу нийтээс ирж байгаа өргөдөл гомдолтой холбоотой асуудлаар энэ 5 жилийн үндсэн төлөвлөгөөнд хэрхэн яаж туссантай холбоотой асуудлаар хэлэлцүүлэг хийхээр байгаа.

Хэлэлцэж байгаа асуудалтай холбогдуулан хуралдаанд оролцож байгаа албан тушаалтнуудыг танилцуулъя.

Жигжидсүрэнгийн Чинбүрэн Эрүүл мэндийн сайд, ЗГ-ын гишүүн ирсэн байна, Жигжидийн Ганбат Сангийн яамны ТНБД, Нэргүйн Мягмар ХЗДХЯ-ны ТНБД, Лхагвасүрэнгийн Мөнхзул Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны ТНБД, Батмөнхийн Насантогтох ЗТЯ-ны ТНБД, Бямбасүрэнгийн Даваацэрэн Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яамны ТНБД-ын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч, Мянгаагийн Баяраа Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яамны ТНБД, Шаравын Мөнхцэрэн ЗГХЭГ-ын Салбарын бодлого зохицуулалтын газрын дарга, Болдын Цэнгэл ТӨБЗГ-ын дарга, Баатарчулууны Золбоо Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газрын Үнэлгээ, мониторингийн газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч, Булгаагийн Ганбат Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайдын зөвлөх, Ганхуягийн Цэрэнжаргал НҮБ-ын хөгжлийн хөтөлбөрийн төслийн үр дүнд суурилсан төлөвлөлтийн зөвлөх, Хаш-Эрдэнийн Сүрэнхорол Эдийн засаг, хөгжлийн яамны Хөгжлийн нэгдсэн бодлого, төлөвлөлтийн газрын дарга, Лхагвабаярын Энх-Амгалан Эдийн засаг, хөгжлийн яамны Макро эдийн засгийн бодлогын газрын дарга. Батболдын Мөнхтөр Эдийн засаг, хөгжлийн яамны Шинжлэх ухааны технологийн бодлогын Бодлого төлөвлөлтийн газрын дарга, Мижиддоржийн Санжаадорж Сангийн яамны Төсвийн бодлого төлөвлөлтийн газрын дарга, Жамьяншаравын Дэлгэржаргал Сангийн яамны Хөгжлийн санхүүжилт, хөрөнгө оруулалтын газрын дарга, Баасансүрэнгийн Алимаа Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Хөдөлмөр эрхлэлт, хөдөлмөрийн харилцааны газрын дарга, Юрагийн Отгонбилиг Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Нийгмийн халамжийн бодлогын газрын дарга, Ванчингийн Рэнцэнханд Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Нийгмийн даатгал, хуримтлалын бодлогын газрын дарга, Ганбадраагийн Батбаяр ЗТЯ-ны Бодлого, хот

төлөвлөлтийн газрын дарга, Оюуны Одбаяр Хот байгуулалт, барилга орон сууцжуулалтын яамны Хот байгуулалт, орон сууцжуулалтын бодлого зохицуулалтын газрын дарга, Баярмаагийн Туяа ЭМЯ-ны Бодлого төлөвлөлтийн газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч, Батчулууны Мөнгөнсүх Эдийн засаг, хөгжлийн яамны Хөгжлийн нэгдсэн бодлого төлөвлөлтийн газрын Салбар дундын бодлого төлөвлөлтийн хэлтсийн дарга, Пүрэвдоржийн Чандмань Эдийн засаг, хөгжлийн яамны Хөгжлийн нэгдсэн бодлого төлөвлөлтийн газрын Тогтвортой хөгжлийн нийгмийн бодлогын хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч, Батжаргалын Төгөлдөр Эдийн засаг, хөгжлийн яамны Хөрөнгө оруулалтын бодлогын газрын Хөгжлийн төсөл хөрөнгө оруулалтын удирдлагын хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч, Батхишигийн Мөнх-Эрдэнэ Эдийн засаг, хөгжлийн яамны Хөрөнгө оруулалтын бодлогын газрын Ногоон санхүүжилтийн бодлогын хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч, Зиаханы Райынбек Эдийн засаг, хөгжлийн яамны Хөгжлийн нэгдсэн бодлого төлөвлөлтийн газрын Салбар дундын бодлого төлөвлөлтийн газрын хэлтсийн ахлах мэргэжилтэн, Галиндэвийн Отгонцэцэг Эдийн засаг, хөгжлийн яамны Хөгжлийн нэгдсэн бодлого төлөвлөлтийн газрын Салбар дундын бодлого төлөвлөлтийн хэлтсийн ахлах мэргэжилтэн, Доеддоржийн Сугар Эдийн засаг, хөгжлийн яамны Хөрөнгө оруулалтын бодлогын газрын ахлах шинжээч гэсэн ийм бүрэлдэхүүнтэйгээр оролцож байна аа.

Хэлэлцэж байгаа асуудалтай холбогдуулан асуулт асууж, үг хэлэх гишүүд нэрсээ өгнө үү? Асуулт үг хамтдаа явчихъя.

Пунсалмаа гишүүнээр тасаллаа. Нийт 5 гишүүн асуулт асууж, үг хэлнэ.

Дарааллын дагуу Сүхбаатарын Эрдэнэбат гишүүн асуулт асууж, үг хэлье.

С.Эрдэнэбат: 5 жилийн төлөвлөгөөн дээр жирийн иргэд энэ төлөвлөгөөг хараад ойлгодог байх хэрэгтэй байна аа. Хувийн хэвшлийн байгууллагууд бас тодорхой мэдээлэл нь ойлгомжтой байх ийм шалгууруудыг бол багцлаад яг энэ олон шалгууруудыг нэгтгээд захын дундаж боловсролтой иргэн гэхэд энийг шууд 100 хувь ойлгодог ийм л юу байх хэрэгтэй байгаад байгаа юм. Тэгэхээр сүүлийн жилүүдэд бид нар янз бүрийн төлөвлөгөө батлаад тэрийгээ хэмжих үр дүнгийнх хэмжилтүүдийг янз бүрээр бичсэнээс болоод тэгээд яг хаана яваад байгаа юм ямар ямар үр дүн гараад байгаа юм гэдэг зүйлүүдээ байнга ингээд өөрчлөөд байхаар ерөөсөө ингээд будилаад болдоггүй.

Тийм учраас би нэг тодорхой нэг хэдэн асуултыг асуугаадахъя аа.

Иргэдийн бодит орлого ирэх 5 жил яаж өсөх юм бэ? Жилд дунджаар яаж өсөх юм бэ гэдэг 1 дүгээрт дундаж цалин хөлс яаж өсөх юм?

ДНБ-д эзлэх цалин хөлсний хэмжээ гэдэг үзүүлэлт байдаг. Олон улсын жишгээр 45 буюу түүнээс дээш нөгөө баялгийн шударга хуваарилалт* хөдөлмөр эрхэлж байгаа хүмүүсийн өдөөх идэвхжил бол сайн байх гэдэг ийм үзүүлэлт байдаг. Манай улс энэнээсээ хоцорч явдаг. Тийм учраас ийм үзүүлэлтүүдийг хэрэглэхгүй юм уу? Би олж хараагүй цалин хөлс, дотоодын бүтээгдэхүүнд.

Хоёрдугаарт аз жаргалын индекс гэдэг ийм үзүүлэлт бас байдаг. Бүүр багцлаад иргэдийн маш олон талын боловсрол, эрүүл мэнд, нийгмийн хамгаалал,

хүрээлэн буй орчин энэ тэр гээд. Энэ үзүүлэлтийг ашигласан уу? Би бас хайгаад олсонгүй. Хэрвээ байхгүй бол ашигламаар байна. Нийгмийн түншлэлийг хөгжүүлэе гээд байхаар энэ ажил олгогч бизнесийн байгууллагуудын төлөөллийн байгууллагууд, иргэний нийгмийн байгууллагууд, үйлдвэрчний эвлэл гээд энэ байгууллагуудаас ер нь асуусан уу? Ирэх 5 жил хэдүүлээ нийгмийн түншлэлийг ингэж хөгжүүлээд, ийм ийм асуудлууд дээр шийдье гэдэг тал дээр.

Гуравдугаарт нь өмчийн эрхийн баталгаажилт гээд 4.1.4 дээр түрүүн би бас байнгын хороон дээрээ асуусан. 2024 онд 11 хувьтай байсан байна. Эрхийн бодит орлогын өсөлт. Хэт өндөр байгаа учраас одоо бид нар ирэх жил 5 хувь, жилд нэг 5 хувийн үзүүлэлттэй л байя гэж төлөвлөж байна гэж хэлж байгаа юм. Тэгэхээр суурь түвшнээсээ бууруулж төлөвлөдөг гээд байгааг бас сайн ойлгохгүй байна л даа миний хувьд.

Тийм учраас энэ тал дээрээ нэг дахиад нэг тодорхой тайлбар өгөөч гэж хэлмээр байна. Төсвийн урсгал зардлыг бууруулна гээд тавьчихсан байна. Нөгөө талд нь иргэдийн цалин хөлс орлогыг нэмэгдүүлнэ гээд. Тэгэхээр энэ 2 чинь хоорондоо зөрчилддөг. Урсгал зардал дотор чинь тэтгэвэр тэтгэмж, цалин хөлс, эрүүл мэнд, боловсролын үйлчилгээ гээд олон юм ордог. Тэгээд ийм зөрчилтэй асуудлууд ингээд гарч ирээд байх юм энийг яах юм бэ? Зээлийн хүүг ер нь яаж бууруулъя гэж бодож байна вэ? Одоо манай moody's бусад олон улсын санхүүгийн байгууллагуудаас аваад байгаа онооны үр дүнд Монгол дахь санхүүгийн зээлийн хүү буурах ёстой. Энэний дагуу ААНБ, иргэд, ахмад, хүүхдүүдэд зориулах тэр зээлийн хүүнүүд буурах ёстой. Тэгэхээр энэ зээлийн хүүг яаж төлөвлөж байгаа вэ гэдгийг асуумаар байна.

Мөн зарим зүйл дээр ингээд энэ байгаль орчныхон байвал хариулчхаарай гэж бодож байна. Тусгай хамгаалалттай газрын тоог нэмнэ гээд байгаа юм. Тухайлбал одоо энэ түрүүн энэ зун би бас зарим сумдаар явсан хөвсгөлийн хойд талын 5 сум гэхэд 97 хувь нь тусгай хамгаалалттай газар байгаа шүү дээ. 5 сум нь. Тэгээд мал бэлчээе гэхээр байдаггүй. Тусгай хамгаалалт гээд оруулдаггүй. Хашаа түлээгээ авъя гэхээр оруулдаггүй. Тэгээд тэнд үндсэндээ бараг хүн битгий амьдар гээд тэр нутгийг эзэнгүйдүүлээд оронд нь нэг баахан амралтын газрууд тусгай эрхтэй тансаг тийм амралтын газрууд байгуулдаг л юм шиг байгаа юм л даа. Тэгэхээр энийг яг юу гэж бодож байгаа вэ?

О.Номинчимэг: 6 номер асуултад хариулъя нэрээ хэлээд.

Р.Сүрэнхорол: Эдийн засаг, хөгжлийн яам Сүрэнхорол. Хөгжлийн бодлого төлөвлөлт түүний удирдлагын тухай хуульд заасны дагуу бид нар үр дүнд суурилсан төлөвлөлтийн арга зүйд үндэслээд 5 жилийн үндсэн чиглэлээ боловсруулж орж ирж байгаа. Тэгэхээр энэ арга зүйнхээ хүрээнд яаж байна гэхлээр бид нар өмнөх 5 жилээсээ бас ялгамжтай байдлаар тодорхой үйл ажиллагаа арга хэмжээг тусгах биш үр дүнд суурилсан төлөвлөлтийг бас боловсруулж Улсын Их Хуралд өргөн мэдүүлээд хэлэлцүүлж байна энэ хүрээндээ 5 жилийн үндсэн чиглэлээ бид нар нэгдмэл уялдааг хангах салбар хоорондын уялдааг хангах, дээрээс нь бодлогын уялдааг хангах гэсэн агуулгаар бас боловсруулж орж ирж байгаа.

Тэгэхээр яг энэ хүрээндээ 5 жилийн үндсэн чиглэл, 8 үндсэн чиглэлийг тусгаад, 8 үндсэн чиглэлийнхээ хүрээнд үндэсний 10 үр дүн салбарын 35, одоо төсвийн ерөнхийлөн захирагчийн 85 үр дүн, дээрээс нь хөтөлбөрийн 200 үр дүн,

нийлээд 330 үр дүнг тодорхойлж оруулж ирж байгаа. Тэгээд 330 үр дүнг тусгахтайгаа холбогдуулаад үндсэн чиглэлийнхээ 3 дугаар хавсралт дээр шалгуур үзүүлэлт, хүрэх түвшнээ бол жил бүрээр нь ялгамжтай байдлаар тусгаж Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хуульд нийцүүлж орж ирж байгаа. Цалин хөлстэй холбоотой үзүүлэлтийн хувьд үндсэн чиглэлийн төсөлд тусгахдаа. Монгол Улсад нийт цалин хөлстэй ажиллагчдын 14.9 хувь нь бага цалин хөлстэй байгааг 2030 онд 13 хувь болгож бууруулах. Мөн бас нэг тусгасан үр дүн нь юу вэ гэхлээр бүтээмж гүйцэтгэлд суурилсан цалин хөлсний тогтолцоог сайжруулснаар ажиллагчдын цагийн дундаж цалинг 2024 онд 9,2 мянган төгрөг байгааг 17.4 мянган төгрөг болгож 2030 онд нэмэгдүүлнэ гэж тусгаж байгаа юм.

Тэгэхээр дундаж цалин маань өөрөөр хэлэх юм бол 2030 онд бол 4 сая дөхнө гэсэн төсөөлөлтэйгөөр Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамтай яг үр дүнг тодорхойлж орж ирж тусгасан байгаад байгаа юм.

Дээрээс нь нь ерөнхийдөө 5 жилийн үндсэн чиглэлийг бас боловсруулахдаа бид нар олон нийтийн оролцоог хангах гэдэг бас нэг хуулийн шаардлага байдаг. Тэр хуулийн шаардлагатай нийцүүлээд төсвийн ерөнхийлөн захирагчтайгаа нийт 14 удаагийн бас хэлэлцүүлэг зохион байгуулсан. Энэ хүрээндээ өөрөөр хэлэх юм бол нөгөө төсвийн ерөнхийлөн захирагчдын маань хүрээнд ажилладаг ТББ, олон нийтийн байгууллага гэсэн байгууллагуудынхаа оролцоог хангаад тэдгээрийнх нь саналыг бол нэгтгэлийг гаргаад нийт хэлэлцүүлгийн явцад 644 санал гарсан. Тэдгээр саналуудаас хууль тогтоомжид нь нийцүүлээд холбогдох саналуудыг тусгасан байгаад байгаа.

Ж.Чинбүрэн: 5 номер Чинбүрэн сайд.

Тэгэхээр Эрдэнэбат гишүүний бас таны хэлж байгаа зүйтэй. Ер нь олон нийтэд яаж энэ хялбар ойлгомжтой, ирээдүйд 5 жилд Монгол Улс маань ямар зорилго дэвшүүлж яаж хөгжих гэж байгаа юм гэдгээ тодорхой харуулъя гэж байгаа. Тэгэхлээр ЗГ-аас тогтоолын төслийг боловсруулахад яам болгон салбар болгон нэлээдгүй их хүч гаргаж ажиллаж ирээдүйн 5 жилийн зорилгоо тодорхойлоод та бүхэнд өргөн барьсан байгаа.

Ингээд Улсын Их Хурлаас тогтоолын төсөл батлагдсаны дараагаар бид иргэдэд салбар бүр тухайн чиглэлээрээ иргэддээ ирэх 5 жилдээ яаж гаргах вэ гэдэг энэ ойлгомжтой хэлбэрээр гаргах юм шүү. Тэгэхээр одоо Их Хурлын гишүүд та бүхний сайжруулж тогтоолын төсөл дээр санал бодлоо оруулаад, ажиллаад эцэслээд баталсны дараагаар энэ ажил хийгдэнэ. Аз жаргалын индексийн тухай түрүүн бас ярьсан. Тэгэхээр бид энэ дээр гол орсон үзүүлэлт бол хүний хөгжлийн үзүүлэлт нэлээн тулгуу орсон байгаа. Хүний хөгжлийн үзүүлэлт маань өөрөө бас дэлхий даяараа баримталдаг үндсэн 3 зарчмыг яадаг энэ бол эрүүл мэнд.

О.Номинчимэг: 5 номер нэмэлт нэг минут, гүйцээж хариулна.

Ж.Чинбүрэн: Тэгэхлээр эрүүл мэндийн хөгжлийн үзүүлэлтээрээ Монгол Улс 07 буюу дундаас дээр үзүүлэлттэй байгаа. Энд эрүүл мэнд, насжилт, боловсрол, амьжиргааны өртөг, тэр нь амьдралдаа хүрч байгаа эсэх энэ тэр гэсэн гол үндсэн үзүүлэлтүүдийг тусгаж авдаг учраас энэ үзүүлэлтээ бид бас аз жаргалын индекс рүү бас дөхүүлж яахад ажлын хэсэг дээр та бүхэн энийг дэлгэрүүлээд томъёоллыг нь жоохон тэлээд оруулахад бас тийм боломжгүй зүйл биш гэж харж байна.

О.Номинчимэг: Байгаль орчны яамнаас байна уу? Нэг номер хариулъя.

Ш.Батбаяр: Байгаль орчны яам ТНБД Батбаяр байна аа. Эрдэнэбат гишүүний асуултад хариулъя. Манай улс ТХГН-ийнхаа хэмжээг 30 хувьд хүргээ гэдэг зорилт тавиад 2035 он хүртэл хөтөлбөр хэрэгжүүлээд ажиллаж байгаа. Хөвсгөл аймгийн хувьд 3 сумд тусгай хамгаалалттай газар байгаа. Тэгэхээр энэ газрууд маань орчны бүсэд нь мал бүхий иргэд амьдрах асуудлыг Байгаль орчны яамнаас дэмжиж гаднын төсөл хөтөлбөрүүдээр энэ орчны бүсийн малчдын амьжиргааг дэмжих хөтөлбөр хэрэгжүүлж байгаль хамгаалах боловсролыг дэмжих чиглэлээр ажиллаж байгаа. Ер нь энэ 30 хувьд хүргэх зорилт маань НҮБ-ын өмнө тавьчихсан зорилт учраас бид тодорхой газруудыг байгалийн нөөц газар, сав газруудаа хамруулаад шинэ хуулиараа оруулаад явчхаж байгаа. Тэгэхээр яг иргэдийн малчдын амьжиргаанд бол тийм сөрөг нөлөө багатай гэж бид үзэж байгаа.

О.Номинчимэг: Сангийн яамнаас. 7 номер.

Л.Энх-Амгалан: Эдийн засаг, хөгжлийн яам.

Гишүүний асуултад хариулъя. Эдийн засаг, хөгжлийн яам Энх-Амгалан. Өрхийн орлогын өсөлттэй холбоотой баримт бичгийн төсөл дээр бол суурин он буюу 2024 оны эдийн өрхийн орлогын өсөлтийг 11 хувь ирээдүйн 5 жилийн дундаж өсөлтийг 5 хувь гэж оруулсан байгаа. 5 хувь өрхийн орлогын өмнөх жилүүдийн өсөлтийг харвал 2016-2020 оны 5 жилд бол өрхийн орлого дунджаар 3 хувиар өсөж байсан байгаа. 2021-2024 оны 5 жилд өрхийн орлогын өсөлт нь дунджаар 5 хувьтай. Гэхдээ 2024 оны хувьд бол цалин хөлс нэлээд нэмсэн учраас өсөлт нь өндөр байгаа.

Дараагийн 5 жилийн өсөлтийг бол өмнөх 5 жилийн өсөлтөөс ахиулаад 5 хувь болгож ингэж л тавьсан зорилт байгаа. Өмнөх 5 жилийн дундаж өсөлтөөсөө 1 нэгж хувиар өндрөөр өсгөө гэсэн ийм зорилтыг л оруулж ирж байгаа гэсэн үг.

О.Номинчимэг: 7 номер гүйцээж хариулъя нэг минут өгье.

Зээлийн хүүг хэрхэн бууруулах вэ гэдэг асуулт асуусан. Энэ дээр бол Монголбанкнаас өгч байгаа тайлбараар бол зээлийн хүүгийн 60-70 хувь нь эх үүсвэрийн зардал байна гэж хэлж байгаа юм. Эх үүсвэрийн зардал гэдэг бол цаанаа хадгаламжийн хүүтэй холбоотой. Хадгаламжийн хүү нь өндөр байдгийн шалтгаан нь бол инфляц өндөр байдагтай л холбоотой.

Тэгэхээр зээлийн хүү буурах үндсэн нөхцөл бол инфляц буурсны дараа л зээлийн хүү буурах үндсэн нөхцөл бүрдэх юм гэж хэлж болно. Инфляцыг бууруулахын тулд Засгийн газрын зүгээс бол төсвийн урсгал зардлаа зохистой түвшинд хязгаарлая гэдэг бодлого явуулж байгаа. Монголбанкны хувьд бол мөнгөний бодлогын тохируулгаа оновчтой хийх асуудал л байгаа юм. Ингэж байж л инфляц буурч байж зээлийн хүү буурах нөхцөл бүрдэнэ гэж хариулж болно.

О.Номинчимэг: Сангийн яамнаас төсвийн бүтэц урсгал зардал болон хөрөнгө оруулалтын бүтцийн хувь, хэмжээтэй холбоотойгоор 3 номер. Санжаадорж дарга.

М.Санжаадорж: Сангийн яам Санжаадорж гишүүний асуултад хариулъя.

Тэгэхээр урсгал зардлыг бууруулж байна гэж бол ойлгож болохгүй. ДНБ-д эзлэх хуваарь ярьж байгаа. ДНБ маань өөрөө жил болгон өсөж байгаа. Энийг юу гэж ойлгох вэ гэхээр эдийн засагт эзэлж байгаа төрийн оролцоог ямар түвшинд барих вэ гэдэг тэр агуулгаар нь л харах ёстой байгаад байгаа юм.

Эдийн засаг дахь төрийн оролцоо хэдий хэмжээний бага байна тэр тусмаа хувийн хэвшилд бол бага хүүтэй зээлийн олдоц нэмэгдэнэ. Энэ нь өөрөө хувийн хэвшлээ бас дэмжих бодлогын нэг хэсэг болчхоод байгаа юм. Тэгэхлээр ДНБ буюу бүтээмж нэмэгдэж байж нөгөө талдаа цалин хөлсөө нэмье гэдэг ийм л бодлого ярьж байгаа юм. Тэрнээс биш юу гэдэг юм шууд огцмоор тодорхой дүн тавингуутаа тийм дүнгээр цалинг тэд болгоно гэдэг байдлаар тооцоо судалгаагүйгээр эдийн засаг дахь имфактыг нь тооцохгүйгээр бол хийж болохгүй гэдэг ийм байр суурийг л Засгийн газар барьж байгаа юм.

О.Номинчимэг: Эрдэнэбат гишүүн тодруулъя.

С.Эрдэнэбат: Тэгэхээр өнөөдөр манай Монголд ажиллаж амьдарч байгаа залуучууд хэзээ нэг мянган долларын цалин дор хаяж авна даа л гэж мөрөөдөж байгаа шүү дээ. Тэгээд энд хэзээ хүрэх юм бэ? Та хэд ингээд нэг ийм чөтгөрийн тойрог шиг юм яриад ингээд инфляцыг бага болгохын тулд урсгал зардлыг бага, урсгал зардал бага байхаар цалин нэмж болохгүй, тэтгэвэр нэмж болохгүй, тэгээд урсгал зардал багасангуут энэ тэгээд ер нь юу ч нэмэхгүй тэгж байгаад хүмүүсийн амьдрал одоогийнхоо байгаа түвшинд байвал гэдэг байдлаар л хариулаад байх шиг сонсогдоод байгаа. Би урсгал зардал дээр дахиад нэг юм хэлье. Төсөв дээр бас зөндөө удаа хэлсэн. Энэ эрүүл мэнд, нийгмийн даатгалын сангийн нийтдээ бараг зургаа төсвийн чинь нэлээн хувийг эзэлж байгаа юмыг урсгал зардлаасаа хэзээ гаргах юм бэ? Ирэх 5 жилийн төлөвлөгөөнд чинь ерөөсөө орж ирээгүй байна. Та бүгд нөгөө дор хаяж 3, 4 жил шаардана гээд байсан. Иргэдийн өөрөө өөрсдөө төлж байгаа мөнгийг, төрийн мөнгө рүү орж ирж төсөвтэй хамт холиод тэгээд урсгал зардал үнэ өндөр байгаа гэдэг байдлаар оруулж ирээд байгаа.

Тэгээд энийгээ төлөвлөгөөндөө тусгасан уу?

О.Номинчимэг: 3 номер.

М.Санжаадорж: Сангийн яам Санжаадорж гишүүний асуултад хариулъя. Нийгмийн даатгал, Эрүүл мэндийн даатгалын санг төсвөөс гаргахгүй ээ. Энэ өөрөө бол шимтгэлийн орлогоор бол тодорхой хэмжээнд бүрдэж байгаа боловч нөгөө талдаа бол энэ санхүүгийн сахилга хариуцлагын асуудал байгаа. Энийг бол манай хувийн хэвшил бол бүхэлд нь авч явах юм бол чадавх боломж бол хэзээ бүрдэх юм тэр үед нь бол бид нар гаргах асуудлыг ярих нь зөв байх. Гэхдээ дэлхийн олон оронд энийг төр өөрөө аваад явж байдаг ийм бол сангууд байгаад байгаа. Нөгөө талдаа эрүүл мэндийн даатгал ЭМД-ын санг гаргалаа гээд төсөв дээр орон зай үүсэхгүй ээ. Төсвийн бусад орлого нь бол өөрөө бол хувь хэмжээгээр тогтоочихсон байдаг. Яг тэр хэмжээгээрээ л төсвийн орлого буурчихна.

Тэгэхээр зарцуулах зарлага маань бол яг тэр түвшиндээ л байж байна. Тэгэхээр бол төсөв дээр бүтцийн нөгөө талд нь цалин нэмэх тийм орон зай энэ дээр гарч ирэхгүй.

О.Номинчимэг: Дахин тодруулъя Эрдэнэбат гишүүн.

С.Эрдэнэбат: Эрүүл мэнд нийгмийн даатгалын санг би төр хариуцах хариуцахгүй гэж яриагүй. Дотоодын бүтээгдэхүүнээс урсгал зардал тооцоод байгаа. Тэр дотроо энэ эрүүл мэнд, нийгмийн даатгалын зардал гэдэг энэ зүйлээ дотор нь оруулаад байгаа учраас наад хорин хэдэн хувь дотор чинь төрийн мөнгө мэтээр харагдаад ингээд яваад байгаа байхгүй юу. Тусад нь тооцох аргачлалаа авч үз ээ.

Өөрөөр хэлбэл иргэд нь төлөөд бүрдүүлж байгаа сангаа урсгал зардал, орлох зардал 2 гэдэг зүйл рүүгээ оруулж ирэхгүйгээр яриач гэдэг л ийм зүйлийг яриад байгаа.

Тэгэхээр төр өөрөө хувийн хэвшлийн салбар бүрэн хариуцаад аваад явна гэж хэлээгүй.

Холимог хэлбэрээр юм уу эс үгүй бол наад тооцож байгаа аргачлалаа тавихгүйгээр өнөөдөр бид нар урсгал зардлаараа суурь салбарууд болсон энэ асуудлаа би зөвхөн цалин яриагүй шүү. Энэ эм тариа, үйлчилгээ, хүүхдийн сандал ширээ гээд энэ олон зардлуудыг л хязгаарлалцаад байгаа чинь сөрөг нөлөөлөөд байна л гэж хэлээд байгаа юм.

О.Номинчимэг: Пунсалмаа гишүүн асуулт асууж, үг хэлье.

Б.Пунсалмаа: Баярлалаа.

Та бүхэнд энэ өдрийн амар амгаланг айлтгая.

Би бол боловсролын салбараас асуулт асуух гээд байна. Монголын ерөнхий боловсролын гадаад хэлний сургалтын чанар өнөөдөр бодитойгоор ямар түвшинд байгааг бид нар харах шаардлагатай байна аа. Монгол хүүхдүүд өнөөдөр англи болон 2 дахь хэлийг 6-аас 12 дугаар анги хүртлээ үзэж байсан. Одоогоор бол 3-аас 12 дугаар анги хүртэл үзэж байна. Нийтдээ 6-аас 9 жил энэ гадаад хэлийг үзэж байгаа. Гэхдээ хүүхдүүд маань төгсөхдөө ийм суурь түвшний гадаад хэлээ бас чөлөөтэй сайн ярьж чадахгүй өндөр түвшинд бэлтгэгдэхгүй байна.

Гэтэл Европын орнууд бол хүүхдүүд нь сургуулиа төгсөхдөө дунд ахисан түвшинд бэлтгэгдэж ажил боловсролын орчинд ажиллахдаа шууд тэр хэлээрээ ярих бүрэн чадвартай ийм хүүхдүүд бэлтгэгдэж байгаа. Тэгэхээр энэ асуудлын ялгаа ер нь юундаа байна вэ? Бид бол яг л ижилхэн олон жил сурч байна зааж байна. Монгол хүмүүс нийтлэгээрээ дунджаараа бол сурах, өндөр бас чадвартай гэж үздэг. Энэ ялгаа хаана гаргаж ирээд байна? Тэгэхээр төгсөж байгаа хүүхдүүдээсээ бид нар IELTS, TOEFL шалгалтын оноогоор дүгнэдэг бол энэ түвшин ахих уу? Энэ асуултыг би Боловсролын яамнаас асууж байна, нэгдүгээрт.

Хоёрдугаарт, ирэх 5 жилийн үндсэн чиглэлд яагаад гадаад хэлний түвшнийг ахиулна гэж оруулж ирсэнгүй вэ? Математик, Монгол хэлний түвшнийг ахиулна гэж оруулж ирсэн. Гадаад хэлний түвшнийг ахиулна гэж оруулж ирсэнгүй. Энэ манай Монгол хүүхдүүдийн гадаад хэлний түвшин хангалттай өндөр түвшинд хүрсэн байна гэж үзэж байгаа юм уу? Тэгэхээр энэ талаар би бол Боловсролын яамнаас асууж байна.

О.Номинчимэг: 4 номер Наранбаяр сайд хариулъя.

П.Наранбаяр: Пунсалмаа гишүүний асуултад хариулъя.

Энэ ер нь гадаад хэл бол өнөөдөр Монголчууд бидний хувьд дэлхий рүү гарах гол цонх л доо. Хоёр том хөршийн дунд байгаа нөхцөлд Англи хэлийг бид бас энэ үндсэн гадаад хэл байна гээд боловсролынхоо хуульд тусгачихсан. Энэ жилээс 3 дугаар ангиас нь орж эхэлсэн. Ноднин жил 100 гаран сургууль туршиж хэрэгжүүлсэн. Пийрсон хөтөлбөрөөр явж байгаа. Энэ хөтөлбөрөөр яг тууштай хичээсэн тохиолдолд, ахисан, дунд түвшний ийм хүүхдүүд гарах бүрэн боломжтой. Ийм болж байгаа. Нэгдүгээрт.

Хоёрдугаарт, яах вэ бас нэг зүйл нэмж тайлбарлаж хэлэхэд Европын улс орнууд нөхцөл байдал нь өөр шүү. Тэр олон үндэстэн холилдож суудаг жижиг газар нутаг дээр маш олон хүн байдаг. Тэгээд Герман, Франц, Англи, Итали, Испани гээд нэг ийм бүлгийн энэ чинь Энэтхэг, Европын хэлний бүлэг шүү дээ. Энэ бүлгийн хэлнүүд холилдож оршдог. Ийм орчин ер нь хос хэлний сургалт тэнд бүр дээр үеэс явчихсан. Манайд хос хэлний сургалт энэ Тува, Казак хэлүүд дээр бас явж байна.

Тэгэхээр ийм орчин дотор англи хэл өөрөө бас ойлголцох гол хэлний нэг болж байгаа гэдгийг бас ойлгох ёстой. Ойлгох бас тийм нөхцөл байдал байдаг. Монгол бол бид нэг үндэстэн. Монгол хэл бол бидний эх хэл. Эх хэлээ сайн судалж үзсэн хүмүүс бол мэдээж гадаад хэлийг маш сайн үзнэ. Өөр дээрээ тогтоож авч, илүү гүнзгий, илүү нарийн бас сурах ийм боломжтой болдог. Бид тэглээ гээд энэ гадаад хэлний сургалтыг хаягдуулж байгаа юм ерөөсөө биш.

Гуравдугаар ангиас нь зааж эхэлж байна. Орчин үеийн заах арга зүйн шилдэг технологид нэвтрүүлж байна. Түүний зэрэгцээ бас энэ гадаад улс орнуудад англи хэлнийхээ багш нарыг үе шаттай бэлдэх ажлыг эхлүүлж байна.

Түүний зэрэгцээ гадаад улс орнуудаас ч гэсэн ийм хэлтэй ийм улсуудыг урих ажлуудыг түлхүү хэрэгжүүлнэ ээ. Ингэснээр бас энэ хэл гэдэг өөрөө хэрэглээний нэг хэсэг байдаг. Тэгэхээрээ шууд ингэж хэрэглэх боломжийг сургуулийн орчинд үүсгэж нэтийг ийм баг ярьдаг багш нар эд нар ингээд орж ирэх юм бол бас боломж нь бас нэмэгдэнэ гэж харж байгаа. Би сая нэг Киргизэд очоод ярилцаж байхад бас хэлж байна лээ. Бас Киргизийн Боловсролын яамны улсууд нь бол үгүй танай Монгол хүүхдүүдийн англи хэл их дажгүй сайн юм байна шүү дээ гээд хэлж байсан.

Тэгэхээрээ би энүүгээрээ юуг хэлэх гээд байна гэхээрээ бид бас энэ тодорхой хэмжээнд ахиц гарч байна. Гэхдээ цаашдаа илүү сайжруулах ийм боломжууд бас байна аа. Тэрийгээ л тийм орон зай боломжоо сайн ашиглаж явъя гэсэн ийм л бодлого барина. Зүгээр та мэдэж байгаа. Орос хэлийг бид одоо үндсэн гадаад хэл шигээ үзэж ирсэн. Радуга гэдэг ийм сурах бичгээр үзэж ирсэн. Дандаа дүрэмд заасаар байгаад л хэн ч ярьж чаддаггүй ийм л хүмүүсийг бэлдсэн шүү дээ. Тэр гашуун сургамжийг бид давтаж болохгүй, давтаж болохгүй. Ийм учраас Персон гэдэг хөтөлбөрөөр явж байгаа. Энэ бол багшийн маш сайн гарын авлагатай. Сурах бичгүүд нь нэлээн сайн боловсорсон юм байгаа. Энийгээ бид үндэсний хөтөлбөр болгох ажлыг бас эхлүүлэх гээд судалгааг нь хийгээд явж байна аа. Ямартай ч бас 3 дугаар ангиасаа үзэж эхэлж байна. Ямартай ч бас багш нараа бэлдэх ажлууд нь явж байна. Бид бас ингээд хэдэн жилийн дараа англи хэлээр илүү сайн түлхүү

ойлгодог, ойлголцдог, хэрэглэж чаддаг, тэрийгээ нэг их тийм тэрэндээ түүртдэггүй ийм шинэ үе гарч ирнэ гэж бодож байна. Баярлалаа.

О.Номинчимэг: Пунсалмаа гишүүн тодруулъя.

Тэгэхээр би танаас тэр пийрсон хөтөлбөр бол би мэдээлэл авсан. Тэр их сайн хөтөлбөр байна. Та харин энэнийхээ зорилтыг яагаад ирэх 5 жилийнхээ чиглэлдээ оруулж ирсэнгүй вэ гэж асуугаад байгаа байхгүй юу. Энэ ирэх 5 жилийн хөтөлбөр бол бид нарын жил болгоны жилийн төлөвлөгөөнд орж явна. Бид нарын гарын авлага гэсэн үг. Тэгэхлээр энэ зорилтдоо та энийгээ оруулах боломж байна уу гэж л асууж байгаа юм. Би бол энэ талаар бол зарчмын зөрүүтэй санал оруулах гэсэн боловч надад бас хол холбогдолтой бас дата мэдээлэл дутсан.

Тийм учраас таныг би энэ зарчмын зөрүүтэй саналаар ч юм уу энэ ирэх 5 жилийн төлөвлөгөө дээрээ энэ сайн хөтөлбөрөө тусгаад илүү дараачийн түвшинд бас энэ Монгол хүүхдүүдийг гадаад хэл суралцах энэ түвшинд хүргээсэй гэж бодож байгаа байхгүй юу. Тэгээд тэрийг хэлж байгаа юм.

О.Номинчимэг: 4 номер Наранбаяр сайд хариулъя.

П.Наранбаяр: Баярлалаа. Бидний энэ хэрэгжүүлж байгаа ажлыг бас дүгнэж хэлж ингэж үнэлж байгаа танд талархал илэрхийлье. Ажлын хэсэг дээр ярилцаад болох байх.

Хоёрдугаарт бас энэ бид жил жилийнхээ төлөвлөгөөг гаргадаг. ЗГ-ын үйл ажиллагааны. Тэрэн дээрээ бас тусгаад явах бас бүрэн боломж бий. Мөн сургуулийн бага боловсролоос авхуулаад дунд ахлахын ингээд шинэчлэлүүд, сургалтын хөтөлбөр явагдаж байгаа. Энэ дээрээ бүрэн тусаад явж байгаа. Баярлалаа.

О.Номинчимэг: Жанчивын Галбадрах гишүүн асуулт асууж үг хэлье.

Ж.Галбадрах: Та бүхэнд өдрийн мэнд хүргэе, оройн мэнд хүргэе. Энэ их чухал асуудал ярьж байгаа. Бид нар энэ Эдийн засаг хөгжлийн яамныхны ингээд боловсруулаад ороод ирж байгаа, базаад ороод ирж байгаа энэ зүйлтэй бас танилцаад их тааламжтай хүлээж авч байгаа. Тэгэхдээ бид нар энийг маш чамбайруулах шаардлагатай байна. Засах шаардлага бас засаж сайжруулах зүйл бас нэлээн байна. Тэгээд ялангуяа судалгаан дээр суурилж явмаар байна. Тэгээд манай яамдуудаас, салбар яамдуудаас юм уу ингээд өгч байгаа тоон дээр бас алдаанууд байна. Энийгээ хянах хэрэгтэй байна. Тэгээд энэ төлөвлөх гэж байгаа учраас бид нар нэг салбараа бас нэг сайхан эрэмбэлээд авчих, өөрөөр хэлбэл салбарт тулгараад байгаа асуудлуудыг ингэж гаргаж ирээд нягталчих ийм боломж энд сайхан бүрдэх юм байна гэж ингэж харж байгаа шүү. Тэгэхдээ мэдээж залгамжтай байна 5 жил учраас. 2026 онд ямар байх юм, 2027 онд ямар байх юм. 2030 онд юунд хүрэх юм гэдэг энэ залгамжийгаа тэгээд тэр өсөлтийг нь бас анхаараад явах хэрэгтэй.

Тэгээд энд бас зайлшгүй оруулах шаардлагатай тийм шалгуур үзүүлэлтүүд бас орхигдсон зүйлүүд бас харагдаад байх шиг байна. Тэгээд би энэ бүгдийг ингээд хэлээд яах вэ? Түрүүн Хүний хөгжил, нийгмийн бодлогын байнгын хороон дээр бас зарчмын зөрөөтэй саналууд гаргаад зарим зүйлээ бас хэлчихсэн. Тэгэхээр энэ тал

дээр бид нар ингээд хамтраад ажиллах хэрэгтэй байна. Тэгээд 1 зарчим барих ёстой. 5 жилийн төлөвлөгөөгөө гаргаад бид нар 2027 оныхоо бас хөгжлийн төлөвлөгөө маань гарч ирнэ. Тэгээд хөгжлийн төлөвлөгөөн дээр тулгуурлаад 2027 оны төсөв маань бас батлагдах ёстой. Бид нар сая 2026 оны төсөв дээр бас л их л харамсалтай л ирэх жилийг боловсролын жил болгож байгаа мөртөө бас олигтой зүйл оруулж чадаагүйдээ бас ийм харамсалтай л байна.

Тэгэхээр ерөөсөө 2027 оны хөгжлийн төлөвлөгөөнд ороогүй зүйлийг төсөвт оруулахгүй гэдэг ийм зарчмаа барина. Тэгэхийн тулд 2027 оны хөгжлийн төлөвлөгөө 5 жилээсээ гарах ёстой тэгээд асуух асуулт байж байна. Тэгээд үндсэн чиглэлийн манай Өргөдлийн байнгын хороо учраас би бас энэ Байнгын хороотойгоо холбогдуулаад асууя.

9.4.2.1. Гадаадын хөрөнгө оруулагчдын өргөдөл гомдлын шийдвэрлэлтийг нэмэгдүүлнэ гэсэн байгаа юм. Тэгээд суурь түвшнээ болохоор 2024 онд хорин тавхан хувьтай гэж авсан байна. Тэгээд би энэ дээр гайхаад байна л даа. ГХО-дын гомдол саналыг шийдвэрлэлт ийм бага байдаг юм уу? Энэ ямар учиртай байдаг юм оо гэдгийг асууя. Тэгээд 2030 онд бол энийгээ 100 хувь хүргэнэ гэсэн байгаа юм. Тэгэхээр энэ Хууль зүйн яамныхан уу? Ямар арга хэмжээ авахаараа ийм богино хугацаанд 100 хувь хүрчихдэг юм бэ?

Хоёрдугаар асуулт. 7.2.2.1 гээд шүүхийн бие даасан хараат бус байдлыг хангах зорилтын хүрээнд иргэдийн хэрэгцээ шаардлагад нийцсэн нээлттэй шүүхийн орчин бүрдсэн байдлыг хангана гээд 2024 онд 0 гээд байгаа байхгүй юу. Тэгэхээр манайх чинь иргэдийн хэрэгцээ шаардлагад нийцсэн нээлттэй шүүхийн засаглал байхгүй улс юм уу гээд. Тэрийгээ 73.8 хувьд.

О.Номинчимэг: Хэн хариулах вэ? ГХО-уудын гомдол маргаантай холбоотой хэсэг. 6 номер Эдийн засаг, хөгжлийн яам.

Х.Сүрэнхорол: Эдийн засаг хөгжлийн яам Сүрэнхорол. Эдийн засаг, хөгжлийн яамнаас Эдийн засгийн эрх чөлөөний тухай анхдагч хуулийн төслийг боловсруулаад явж байгаа. Энэ хүрээндээ болохоор зөвшөөрөл мэдэгдлийн тухай хуулийн нэмэлт, өөрчлөлт мөн дээрээс нь Хөрөнгө оруулалтын тухай хуулийн нэмэлт, өөрчлөлт бас явж байгаа. Тэгээд Их Хуралд өргөн мэдүүлэхэд ерөнхийдөө бэлэн болоод байгаа. ЗГ-ын гишүүдээс саналыг аваад нэгтгэчихсэн байгаа. Өнгөрсөн ЗГ-ын хуралдаанаар бас хуулийнхаа төслийн боловсруулалтын явцыг танилцуулсан.

Хөрөнгө оруулалтын хуулийн боловсруулалт дээр үүсээд байгаа нэг асуудал юу байсан бэ гэхлээр хөрөнгө оруулалтын хуульд бас оруулж байгаа нэмэлт өөрчлөлтийн нэг үндсэн онцлог нь бас юу байгаа вэ гэхлээр хөрөнгө оруулагчдын маргаантай холбоотой гомдлыг шийдвэрлэхтэй холбоотой асуудал бас байгаад байгаа.

Тэгэхээр одоогийнхоо байгаа хуулиар хөрөнгө оруулалтын тухай хуулиар гомдол шийдвэрлэх тэр процесс нь бас ойлгомжгүй байгаад байгаа юм. Тэгэхээр хөрөнгө оруулалтын орчныг сайжруул гэдэг саналын бас нэлээд хувь нь энэ гомдол шийдвэрлэлттэй холбоотой байдаг. Тэгэхээр энэтэй холбоотой нэмэлт, өөрчлөлтийг Хөрөнгө оруулалтын тухай хууль дээр холбогдох яг суурь журамласан зохицуулалтыг нь хууль дээр нь тусгаад явж байгаа юм.

Тэгэхээр өөрөөр хэлэх юм нөгөө журмаар тодорхой төрлийн харилцааг зохицуулахгүй. Яг хуулийнх нь хүрээнд гомдол маргааны шийдвэрлэлттэй холбоотой харилцааг хууль дээр нь тусгаад тэгээд тэр хүрээндээ болохлоор ЗГ-ын хяналт хэрэгжүүлэх газар хөрөнгө оруулагчдын маргааныг шийдвэрлээд тэрэн дээр нь хяналт тавиад хөрөнгө оруулагчдын тусдаа зөвлөл үүсээд зөвлөл маань болохоор маргааныг тэр гомдлыг нь шийдвэрлээд гомдол шийдвэрлэлт маань тодорхой асуудалтай ч байдаг юм уу тэрэн дээр гомдол байгаад байх юм бол ЗГ-ын хяналт хэрэгжүүлэх газар энэ дээр хяналт тавихаар хуулийн нэмэлт, өөрчлөлт нь явж байгаа. 5 жилийн үндсэн чиглэл дээр болохлоор Үндсэн чиглэлийн 2 дугаар хавсралтын 9.4.2.1 дэх хэсэг дээр Хөрөнгө оруулагчдын эрх ашгийг хамгаалах тогтолцоог боловсронгуй болгож ГХО-уудын өргөдөл гомдлын шийдвэрлэлтийг нэмэгдүүлнэ гэдэг үр дүн бас тусгаж орж ирж байгаа. Үр дүнг тусгаж байгаатай холбогдуулаад 3 дугаар хавсралт дээр бас шалгуур үзүүлэлт хүрэх түвшнийг нь бас тусгаж байгаа.

Гуравдугаар хавсралтын 9.4.2.1 дэх хэсэгт гадаадын ГХО-уудын гомдлыг шийдвэрлэсэн байдал 2024 онд 25 хувь байгааг 2030 онд 100 хувьд хүргэнэ гэж байгаа юм. Тэгэхээр бид нар 100 хувьд хүргэх арга замаа болохлоор бид нар юу гэж харж байна гэхлээр хөрөнгө оруулалтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулаад гомдол шийдвэрлэх процессыг нь илүү хяналттай гомдлыг нь тухайн цаг цаг тутамд нь шийдээд асуудлыг нь шийдээд явдаг тэр процессыг нь бас хууль дээр нь тусгаад явж байгаа. Тэгэхлээр энэ асуудал маань шийдэгдэнэ гэж харж байгаа.

О.Номинчимэг: Шүүхтэй холбоотой асуудал. Нээлттэй шүүхтэй холбоотой асуудал хэн хариулах вэ? 2 номер уу Мягмар дарга уу? Хэн хариулах юм? Тэр шалгуур үзүүлэлт зорилтууд хаанаас орж ирсэн юм? Нэг номер Эдийн засаг, хөгжлийн яам.

Б.Мөнгөнсүх: Эдийн. Засаг, хөгжлийн яамны салбар дундын бодлого зохицуулалтын хэлтсийн дарга Мөнгөнсүх гишүүний асуултад хариулъя аа. 5 жилийн үндсэн чиглэлийн бодлогын баримт бичгийн маань нэг онцлог нь юу вэ гэхээр 40 төсвийн ерөнхийлөн захирагчтай бол хамтарч ажиллаж үр дүнгүүдээ бол тодорхойлсон байгаа. Энэ нь бол зөвхөн ЗГ-ын байгууллагууд төдийгүй Улсын Их Хурлаас удирдлага нь томилогддог байгууллагууд, мөн шүүх засаглалын байгууллагуудын үр дүнг бол тодорхойлсноороо онцлог байгаа. Энэ хүрээнд бол засаглал гэсэн хэсэг дээр бараг 20 орчим төсвийн ерөнхийлөн захирагч нартай үр дүнг бол нэг бүрчлэн ингэж тодорхойлсон. ҮХЦ, Улсын дээд шүүх, ШЕЗ гэх мэтчилэн бүх байгууллагуудын оролцоог хангасан байгаа. Энэ хүрээнд бол шүүхийн байгууллагууд маань нөхцөл байдлын дүн шинжилгээнээс эхлээд ингээд судалгаа нөхцөл байдлаа үнэлж ингээд үр дүнгүүдийг тодорхойлсон. Энэ хүрээнд Шүүхийн ерөнхий зөвлөлөөс ирүүлсэн энэ саналд бол иргэдийн хэрэгцээ шаардлагыг бүрэн хангасан ийм шүүхийн барилга байгууламж бол Монгол Улсад байдаггүй гэдэг энэ нөхцөл байдлын дүн шинжилгээний агуулга дээр үндэслэн суурь түвшнийг бол тэг гэсэн энэ ирсэн санал дээр үндэслэн энэ үзүүлэлтээр бол авч тодорхойлсон байгаа.

О.Номинчимэг: Галбадрах гишүүн тодруулъя.

Ж.Галбадрах: Тэгэхээр сая хариулж байна л даа. Хөрөнгө оруулалтын тухай хуулиа сайжруулна. Процессыг нь бас сайжруулалт хийнэ. Авах арга хэмжээнүүдээ төлөвлөнө гээд. Гэхдээ энийгээ бүр их тодорхой хийгээд би гайхаад л байгаа юм.

2025 хувь байсан юмыг 100 хувь хүргэнэ гээд байгаа чинь яг үнэхээр бодитой юм уу? Тэгээд энэ чинь нөгөө өмнөх 5 жилд бид нар чинь маш бага биелэлттэй л юунууд баталчихсан шүү дээ. Зүгээр чанар яриад байсан. Одоо бид нар тоогоор хэмждэг юм руу орох гээд байна шүү дээ. Тэгэхээр энэ арга хэмжээнүүдээ их сайн нарийн төлөвлөх хэрэгтэй байна. Манай Лувсанжамц гишүүн хэлээд байгаа хэмжиж чадахгүй бол төлөвлөж чадахгүй. Төлөвлөж чадахгүй бол хэрэгжүүлж чадахгүй гээд. Тэгэхээр бид нар өнөөдөр хэмжих шалгууруудыг л тэгээд тэрийг яаж явах гэдэг энэ процессыг яриад байгаа. Тэгэхээр энэ тал дээр л бүгдээрээ хамтарч ажиллая.

Би бол боловсролын салбарын хүн. Энэ сургуулиудын тэр стандарт хангасан барилга байгууламж сургуулийн барилгаас эхлээд багшийн хомсдолыг хэрхэн арилгах вэ гэдэг талаар тодорхой саналууд гаргаад ингээд яваад байгаа. Тэгэхээр Их Хурлын.

О.Номинчимэг: Үг хэллээ. Саналуудыг аанай ажлын хэсгийнхэн бас сонсож байгаа байх. Тэгээд энэ дээр том ажлын хэсэг угаасаа Улсын Их Хурлын дэд даргын захирамжаар гарч байгаа учраас энэ саналуудыг тусгаад өшөө сайжруулах зүйлсийг анхаараад авна биз гэж бодож байна.

Ганзоригийн Лувсанжамц гишүүн асуулт асууя.

Г.Лувсанжамц: Оройн мэнд хүргэе. 4 дүгээр хавсралтаас асуулт асуух асуулт байна. Эхнийх нь 4 дүгээр хавсралтаар явж байгаа санхүүжилтийн эх үүсвэр дээр шууд хөрөнгө оруулалт гээд биччихсэн байна. Энэ нь улсын төсөв, орон нутаг, гадаад зээл, тусламжаас ялгаатай ямар төрлийн хөрөнгө оруулалтыг хэлж байгаа юм бол? Эхний асуулт.

Хоёрдугаарх нь 2026 оны төсөв дээрээ та хэд маань иргэдийн санал асуулгыг аваад иргэд 3 салбар дээр л ач холбогдол өгсөн. Энэ 3 салбарыг тэргүүн ээлжид тавиарай гэсэн. Боловсрол, эрүүл мэнд, эрчим хүч тийм ээ. Тэгээд та бүгдийн маань энэ 4 дүгээр хавсралтад байгаа нийтдээ 66 их наяд төгрөгийн хөрөнгө оруулалтуудыг салбараар нь ангилаад үзлээ. Боловсрол, эрүүл мэнд нэмээд шинжлэх ухаан, соёл дээрээ 8 хувь байна. Тэгээд боловсруулах үйлдвэр дэд бүтэц дээр 34 хувь, эрчим хүч 29 хувь, бүсчилсэн хөгжил 25 хувь. Төрийн институтийг чадавхыг сайжруулна гээд 4 хувь байна. Тэгээд энэ бүсчилсэн хөгжил гэдэг нь дотор нь харахлаар замын төслүүд маш их байна. Нийтдээ улсын төсвөөр 19 замын төсөл дээр 3.5 их наяд төгрөгийг төсөвлөсөн байна. Ингээд харахлаар автоматаар бид нар 2030 он хүртэл жил болгон 20 хувийг замын хөрөнгө оруулалт руу хийх гээд байна л даа. Иргэд маань ингээд яг аль салбарыг чухалчилж анхаарч байгаа вэ гэдгээр нь санал хүсэлтээ өгчихсөн байхад 5 жилийн үндсэн чиглэл дээрээ бид нар яг энэ боловсрол, эрүүл мэнд, эрчим хүч гэсэн 3 салбар дээрээ хөрөнгө оруулалтаа түлхүү тавих ёстой байсан юм биш үү? Энэ дээр та хэд маань ямар бодолтойгоор энийг боловсруулж ирсэн бэ?

Гурав дахь асуулт нь Соёлын яамнаас асууя. Хүрэх үр дүн дээр 3.1.1 үндэсний агуулгатай уран бүтээлийн тоог нэмэгдүүлэх гэсэн арга замыгаа бичсэн байна. Хөрөнгө оруулалт дээр 4 дүгээр хавсралтад Үндэсний урлагийн их театрыг барих төсөл дээр 352 тэрбум төгрөг гэж тавьсан байна. Та хэд маань зорилго зорилт тавьчхаад тэрэндээ хүрэх арга замыгаа зөв тодорхойлсон боловч тавьж байгаа хөрөнгө оруулалт нь болохоор төр өөрөө театр барих гэж байгаа гэсэн. Бичиг

баримтаа боловсруулахдаа энийг яаж уялдуулсан юм бол? Эд нар дээрээ тодорхой хариуг авъя аа.

О.Номинчимэг: Хөрөнгө оруулалттай холбоотой асуудал. Хэн хариулах вэ? 7 номер нэрээ хэлээд хариулаарай.

Төгөлдөр: Гишүүний асуултад хариулъя аа. Эдийн засаг, хөгжлийн яам Төгөлдөр. Шууд хөрөнгө оруулалт гэдэг дотор маань болохоор гадаадын шууд хөрөнгө оруулалт, дотоодын шууд хөрөнгө оруулалт тэгээд төрийн өмчийн ААН-үүдийн шууд хөрөнгө оруулалтууд маань ороод явж байгаа. Яг шууд улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөрөөр нь авч үзвэл яг шууд хөрөнгө оруулалтаараа нийт 14 төсөл хэрэгжих гэж байгаа. Бүсчилсэн хөгжлийн хүрээнд яагаад авто замын төслүүд олон орж ирсэн бэ гэдэг дээр болохоор 2024 он, 2025 онд бүсчилсэн хөгжлийн жил болж зарласантай холбоотойгоор авто замын төслүүд шинээр эхлүүлсэн байгаа. Тухайн удаагийн улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөрт шинээр авто замын төсөл нэгийг ч нэмээгүй. 2024, 2025 оны ингээд хэрэгжээд эхэлсэн төслүүд маань ингээд тусгагдаад явсан байгаа.

О.Номинчимэг: 6 номер гүйцээж хариулъя.

Х.Сүрэнхорол: Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хуулиараа үндсэн чиглэлийн төслийг улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөрийн хамт батална аа. Боловсруулж Улсын Их Хуралд өргөн мэдүүлнэ гэдэг хуулийн заалт байдаг. Энэ хүрээндээ болохоор улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөртөө ямар төслүүдийг тусгах ёстой вэ гэхээр 30 тэрбум төгрөгөөс дээш төсөвт өртөгтэй, ТЭЗҮ, зураг төсөл нь боловсруулагдсан урт дунд хугацааны бодлоготой нийцсэн байна гэж заасан байгаад байгаа. Тэгэхээр нөгөө бид нар 5 жилийн үндсэн чиглэлээ боловсруулахдаа Хөгжлийн бодлого, төлөвлөлтийнхөө хуулиар төсвийн ерөнхийлөн захирагчтай хамтран ажиллаж боловсруулалтаа хийж орж ирж байгаа.

Тэгэхээр нөгөө төслүүд маань орж ирэхдээ энэ шаардлагыг хангаж орж ирэх шаардлагатай. Тэгэхээр боловсрол эрүүл мэнд ч байдаг юм уу эдгээр салбарууд дахь орж ирж байгаа төслүүд маань бас хөгжлийн бодлого төлөвлөлтийнхөө хуультай нийцээгүй. Нийцлийг нь хангах гэдэг бас хэрэгцээ шаардлага бас байгаа учраас зарим төслүүд дээр бас.

О.Номинчимэг: Гүйцээж хариулъя. 6 номер.

Х.Сүрэнхорол: Эцэст нь бас Эдийн засаг хөгжлийн сайдын баталсан Улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөр болон 5 жилийн үндсэн чиглэлийг боловсруулах бас аргачлал баталчихсан байдаг. Тэгэхлээр тухайн аргачлал болон хуульдаа нийцсэн төслүүдийг нь бид нар улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөр дээрээ тусгаж жагсааж орж ирсэн гэсэн үг. Тэгэхлээр нөгөө хуулийнхаа шаардлагыг хангахгүй бол тухайн төслүүд маань орж ирэх боломжгүй болчихож байгаа юм. Тэгэхлээр тэр шаардлагадаа нийцээд орж ирсэн төслүүд маань л энэ энэ хүрээн дотор энэ жагсаалт байдлаар орж ирж байгаа.

О.Номинчимэг: Соёлын яам 8 номер.

Б.Даваацэрэн: Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яам Даваацэрэн гишүүний асуултад хариулъя. Энэ Үндэсний урлагийн их театр барих төсөл бол

БНХАУ-ын ЗГ-ын буцалтгүй тусламжийн хөрөнгөөр санхүүжүүлэх ийм төсөл юм байгаа юм. Энэ яриа хэлцэл л зүйлсүүд явагдаж байна. Ирэх жилээс ажлууд эхлээд явахаар тооцогдож байгаа. Энэ төсөл маань бол үндэсний агуулгатай уран бүтээлийн хэрэгжүүлэх зорилтын нэг л илэрхийлэл нь. Энэний ард бол соёл урлагийн байгууллагаар дамжуулан болон соёлын төвөөр дамжуулаад нийтэд түгээх арга хэмжээнүүдийн агуулга дээр бол түрүүний хэлсэн үндэсний агуулгатай уран бүтээлүүдийг хийгээд явах юм байгаа юм.

О.Номинчимэг: Лувсанжамц гишүүн тодруулъя.

Г.Лувсанжамц: Баярлалаа. Соёлын энэ театр маань зээл биш тэгвэл 100 хувь зүгээр манайд өгөх гэж байгаа төсөл байна гэж ойлголоо зөв үү тэ? Ойлголоо. Энэ болохоор нөгөө та хэд маань хууль журамдаа аргачлалдаа нийцүүлээд боловсруулж байгаа гэдгийг маш сайн ойлгож байгаа. Сайн ажиллаж байгаа гэж та хэдийг өндрөөр үнэлж байгаа. Ер нь гэхдээ нөгөө 5 жилийн чиглэлийнхээ бүтцийг бас хэдүүлээ бас ярилцах ёстой. Тэрийгээ та хэд маань дотроо ярилцсан болов уу гэж бодож байна. Хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээ 5 жилийн чиглэл дээр ер нь тусгадаггүй. Хөрөнгө оруулалтыг жил дээрээ тусгаад л явдаг. Тэгээд л дунд хугацааны төсөвтөө шилжсэн орнууд тэрэн дээрээ тусгаад явчихдаг. Тэгэхлээр бид нар дахиад энэ 5 жилийн чиглэлээ хийчхээд 2030 онд дараагийн 5 жилийг хийхдээ дахиад төсөл арга хэмжээ бичнэ гэж орж ирэхдээ дахиад ингээд төсөв тавиад суух байх байхгүй юу. Ийм байдлаар манай улс ингээд хөгжих боломжгүй л гэж хараад байгаа юм. Нөгөө төлөвлөлтийн эрэмбэ нь буруу явчхаад байгаа гэсэн үг л дээ. Энэ дээр та хэд маань ер нь ямархуу хэлэлцүүлгүүдийг өрнүүлсэн бэ?

О.Номинчимэг: 6 номер Сүрэнхорол дарга.

Х.Сүрэнхорол: Ер нь бол Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хуулийнхаа хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээг бас хийх шаардлагатай байгаад байгаа. Тэгэхээр Их Хурал дээр бас гишүүдийн ажлын хэсэг гараад ажиллаж байгаа. Лувсанжамц гишүүн бас өөрөө ахлаад явж байгаа. 185 дугаар ажлын хэсэг явж байгаа. Тэгээд яах вэ ажлын хэсэгтэй бид нар бас хамтран ажиллаад бас явж байгаа. Тэгэхээр энэ хүрээндээ эхлээд хуулийнхаа хэрэгжилтийн үр дагаврыг үнэлээд үнэхээр нөгөө урт дунд хугацааны бодлогын баримт бичгүүдээсээ гадна улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөрийг жишээлбэл хавсралтаар оруулж ирэх ёстой хуулийн зохицуулалт байгаа. Тэгэхээр одоо тэрэн дээрээ бас хуулийн хэрэгжилтийн үр дагаврыг үнэлнэ.

Дээрээс нь гадаад орнуудынхаа бас судалгааг хийгээд тандан судлах шаардлагатай байдаг хууль тогтоомжийнхоо хуулиар. Тэгэхээр тэр судалгаануудаа бэлэн болоод, тэрнийхээ үнэд үр дүн дээр өөрөөр хэлэх юм бол хууль дээрээ нэмэлт, өөрчлөлт оруулах асуудал яригдаад энэ зүйлийг бас нэг талд нь гаргаж шийдвэрлэх нь зүйтэй гэж харж байгаа.

О.Номинчимэг: Лувсанжамц гишүүн тодруулъя.

Г.Лувсанжамц: Баярлалаа. Проактив байгаад шийдэл хайж байгаад баярлалаа. Өнгөрсөн 5 жилийн гүйцэтгэлийн тайлан гэж байгаа болов уу? Тэр байгаа бол ажлын хэсэг дээр бид нар танилцмаар байна. Их Хурлын Тамгын газраас ямар нэгэн байдлаар албан байдлаар бид нарт бичиг ирээгүй байна. Тэгэхээр 5 жилийн, дараагийн 5 жил хэлэлцэж байгаа юм чинь бид нар өнгөрсөн 5 жилээ бас

харах хэрэгтэй байгаа учраас тийм тайлан та хэд маань өөрсдөө гаргасан гэсэн юуг сонссон. Тэгэхээр тэрийг ажлын хэсэгт хүргүүлж өгөхийг хүсэж байна.

О.Номинчимэг: 6 номер.

Х.Сүрэнхорол: ЗГ-ын хяналт хэрэгжүүлэх газраас бол яг нөгөө ЗГ-т Хяналтын тухай хууль гэж байдаг. Тэгэхлээр тэр хуулийнхаа хүрээн дотор өөрөөр хэлэх юм бол өнгөрсөн 2021-ээс 2025 онд хэрэгжсэн 5 жилийн үндсэн чиглэлийнхээ хэрэгжилтэд бас мониторинг хийгээд Улсын Их Хуралд 9 сарын 11-нд ЗГ-аас өргөн мэдүүлчихсэн байгаад байгаа. Тэгэхээр уул нь Их Хурал дээр тайлан маань ирчихсэн. Тэр тайландаа үндэслээд бол бид нар Хөгжлийн бодлого төлөвлөлтийнхөө тухай хуульд нийцүүлээд үр дүнд суурилсан төлөвлөлтийнхөө арга зүйг бариад энэ 5 жилийн үндсэн чиглэлийг боловсруулж орж ирж байгаа юм.

Тэгэхээр Их Хурал дээр ирчихсэн байгаа 9 сарын 11-нд.

О.Номинчимэг: Хүрэлбаатарын. Баасанжаргал гишүүн асуулт асууж үг хэлье.

Х.Баасанжаргал: Би 3 багц асуудалд санал, асуултаа хэлье.

Нэгдүгээрт яг энэ боловсролын салбар дээр боловсролын индекс гээд 1.1 дээр явж байгаа юм. Тэгээд боловсролын индексийг хайгаад хараад үзэхлээр НҮБ-ын л боловсролын индекс юм шиг байна. Би тэгэхдээ зөв яасан уу та нар өөрсдөө бас залруулаад хэлээрэй. Энэ боловсролын индексийг харахаар сургуульд сурсан дундаж хугацаа голдуу яг гол үзүүлэлт болоод явдаг. Тэгээд ингээд та нарын тавьсан үзүүлэлтийг харахаар дандаа 0.01-ээр нэмэгдэхээр харагдаад байгаа байхгүй юу. Тэгэхээр бид нар 5 жилийн дотор дөнгөж 0.1-ээр л нэмэх нь л 0.1 ч хүрэхгүй. Ингээд 0.06 функтээр боловсролын индекс маань нийтдээ нэмэгдэхээр харагдаад байгаа байхгүй юу. Ийм бага үзүүлэлтээр явахаар тэгээд болж байгаа юм уу? Энэ дээрээ тодруулж өгөөч ээ.

Хоёрдугаарт түрүүний шүүхийн төсөв, хөрөнгө оруулалттай холбоотой 7.2.2.1-тэй холбоотой асуулт. Энэ тэг түвшнээс эхлээд ирэх жил 26.2 хувьд хүрэх буюу иргэдийн хэрэгцээ шаардлагад нийцсэн нээлттэй шүүхийн орчин бүрдсэн байдал ирэх жил 26 хувьдаа хүрэх юм байна. 5 жилийн дараа 73 хувь болох юм байна. Нийтдээ манай улсад үйл ажиллагаа явуулж байгаа бүх шүүхүүдийн ямар ч байсан нэг 73.8 хувь нь 5 жилийн дараа нэг хүний наад захын шаардлага хангасан л болох нь гэж харагдаад байгаа байхгүй юу. Гэтэл хөрөнгө оруулалтын төлөвлөгөө дотор чинь тэрэнтэй холбоотой нэг ч төгрөг орж ирээгүй байна. Яаж 73.8 болгоно гэж та хэд хараад байгаа юм? Энэ дотор 30 тэрбумаас дээш төгрөгийн үнийн дүнтэй хөрөнгө оруулалт ордог гэдгийг бид нар мэдэж байгаа.

Тэгэхдээ нийт шүүхийн чинь орчин үйл ажиллагаа сайжрахын тулд 73.8 хувьтай болгохын тулд 30 гаруй байтугай л тэрбум төгрөг болно шүү дээ. Тэгэхээр энэ тооцооллыг яаж хийгээд байгаа юм? Гол нь энэ нөгөө та нар ингэж хөгжинө гээд байгаа чинь хөрөнгө оруулалттайгаа ерөөсөө уялдахгүй байгаа байхгүй юу. Хөрөнгө оруулалттайгаа энэ чинь ерөөсөө уялдахгүй байна.

Гуравдугаарт манай Байнгын хорооны эрхлэх асуудал гол нь иргэдийн өргөдөл мэдээлэл, иргэдийн гаргаад байгаа өргөдөл гомдол өөрөө үр дүнтэй

шийдвэрлэгддэг байх нь аягүй чухал үзүүлэлтийн нэг. Тэрэнтэй холбоотой нэг ч шалгуур үзүүлэлт, нэг ч үр дүн бас байхгүй. Зөвхөн гадаадын хөрөнгө оруулалтын өргөдөл гомдол 25 хувиас өснө, 100 хувь болно л гэсэн өргөдөл гомдол. Тийм 3 хувь байгаад байна аа. Ийм 3 асуулт.

Санал гэх юм бол ер нь тэгээд л бид нарыг яг ингээд шахах гээд л байна л даа. 11 сарын 31-ний дотор батлах ёстой гээд л ингээд л нэг ийм хам хум байдлаар бид нар ингээд л нэг хэлсэн болоод л, ярьсан болоод л, ажилласан болоод л батлах гээд байна. Энэ чинь бүхэл бүтэн Монгол Улсын дараагийн 5 жилийн үндсэн чиглэл.

Дээрээс нь дараагийн 5 жилийн үндсэн хөрөнгө оруулалтуудыг бид нар шийдэх гээд сууж байгаа байхгүй юу. Тэгэхээр энэ процесс яг үнэндээ үнэхээр тийм үр нөлөөтэй үр дүнтэй процесс одоо яг Их Хурал дээр үнэхээр явж чадахгүй байна. Ямар ч ингээд санал энд зүйлүүдийн уялдаа холбоо, тоо, харах, дахин дахин хэлэлцэх ийм зүйл ерөөсөө болохгүй байна аа. Тэгэхээр энэ процессыг сайжруулах тал дээр бас Эдийн засаг, хөгжлийн яам.

О.Номинчимэг: Эхний асуулт. Боловсролын индекстэй холбоотой 4 номер Наранбаяр сайд.

П.Наранбаяр: Баярлалаа. Тэгэхээр энэ боловсролын индекс бол, боловсролын хүртээмж, боловсролын дотоод үр ашиг, боловсролын үр дүн, боловсролын салбарын зардал, хүний нөөцийн үзүүлэлт гэсэн ийм 4 бүлгээс бүрддэг. Эдгээр үзүүлэлтийг хэмжсэнээр Монгол Улс олон улсын түвшинд хаана байгаагаа тооцоход бол энэ, мөн сайжруулах боломжийг хайж олоход энэ тус болдог. Сүүлийн 5 жилийн хугацаанд боловсролын индекс харьцангуй өндөр түвшинд байсан чинь 2022 оноос эхлэн буурах хандлагатай. Энэ 2023-2024 онуудад нэлээн ийм буурсан чигээрээ тэр хадгалагдаад байгаа. Тэгэхээрээ ирэх 5 жилд бол бид боловсролын салбарын хөгжлийн гол зорилго нь бол хүн бүр чанартай, хүртээмжтэй боловсрол эзэмших тэгш боломжийг бүрдүүлж, мэдлэгт суурилсан, өрсөлдөх чадвартай ийм иргэн төлөвшүүлэхэд оршиж байгаа. Тэгээд энэ хүрээндээ үндсэн чиглэлийн хавсралтын 3.1.1-д тусгасан байдлаар боловсролын индексийг 0.755 байгааг 0.810 хүргэж өсгөнө өө гэсэн байгаа. Энэ НҮБ-ын энэ багцалсан юугаар аргачлалаар бол нолиос нэгийн хооронд энэ явдаг.

Тэгэхээрээ энэ хэдийгээр ингээд харахад мянганы нарийвчлалтайгаар аравтын, зуутын нарийвчлалтайгаар өсөж байгаа ч гэсэн энэ дээр бид бас цаана нь энэ эдгээр 4 бүлгээр ажлаа сайжруулсны үр дүнд ингэж гарч ирдэг гэдгийг хэлье. Тэгэхээр энэ нь бол нэлээн тийм сайн урагшаа явсан ийм үзүүлэлт болно оо гэсэн утгатай юм аа. Зүгээр бидний хувьд бол одоо ингээд энэ боловсролыг дэмжих жилийн хүрээнд өнөөдөр хүртээмжийн асуудлыг мөн багшийн цалингийн асуудлыг бас нэлээд хэмжээнд шийдэхээр ингэж орж ирсэн. Тэгэхээр энэ дээрээ бид энийгээ сайн хэрэгжүүлээд үнэхээрийн гүйцэтгэл сайтай гарч гарах юм бол энэхүү хүртээмж үр ашиг талдаа бас нэлээн сайжирсан ийм үзүүлэлтүүд гарах болов уу гэсэн ийм хүлээлттэй байгаа гэдгээ хэлье. Баярлалаа.

О.Номинчимэг: Шүүхийн хөрөнгө оруулалттай холбоотой. 6 номер уу?

Х.Сүрэнхорол: Эдийн засаг, хөгжлийн яам Сүрэнхорол. Шүүхийн хөрөнгө оруулалт гэхээс яах вэ? Нөгөө хөрөнгө оруулалтын хөтөлбөртэй холбоотой асуудал дээр гишүүний асуултад бас хариулъя.

Хөгжлийн бодлого төлөвлөлт түүний удирдлагын тухай хууль дээр түрүүн бас хариулсан. Хөрөнгө оруулалтын хөтөлбөрийг боловсруулахдаа тодорхой төсөл арга хэмжээнүүдийг тусгах ёстой байдаг. Энэ хүрээн дотор болохоор өөрөөр хэлэх юм бол тухайн төсөл арга хэмжээ маань 3 шаардлагыг хангах ёстой байгаад байгаа юм. 30 тэрбум төгрөгөөс дээш төсөвт өртөгтэй ТЭЗҮ, зураг төсөл нь боловсруулагдсан. Урт, дунд хугацааны бодлоготой нийцсэн байх ёстой гэж. Тэгэхээр энэ шаардлагыг хангасан төслүүд маань л яг энэ жагсаалт байдлаар орж ирээд байгаа юм. Тэгэнгүүт 5 жилийн үндсэн энэ чиглэл маань цаашаа хэрхэн яаж задарч бас арга хэмжээ болж хэрэгжиж явах вэ гэдэг асуудлыг бид нар 5 жилийн үндсэн чиглэлийг дагуулаад гэх юм уу Их Хурлын тогтоолын төсөл орж ирсэн байгаа.

Их Хурлын тогтоолынхоо төслийн 2 дугаар заалт дээр бол яг энэ төсөл.

О.Номинчимэг: 6 номер гүйцээж хариулъя.

Х.Сүрэнхорол: Төсөл арга хэмжээнүүдийг болохоор жилийн хөгжлийн төлөвлөгөө дээр тусгаад санхүүжилтийг нь тусгаад яваарай гэдэг засагт даалгасан бас холбогдох зохицуулалтыг энэ дотор бас тусгачихсан байгаад байгаа. Өөрөөр хэлэх юм бол агуулга нь юу байна гэхээр Монгол Улсын 2026-2030 онд хөгжүүлэх 5 жилийн үндсэн чиглэл, Монгол Улсын 2026-аас 2030 оны Хөрөнгө оруулалтын хөтөлбөрийн хэрэгжилтийг зохион байгуулахдаа улсын эдийн засгийн нөхцөл байдал, бодлогын тэргүүлэх чиглэлтэй уялдуулаад төсөл арга хэмжээг улсын хөгжлийн жилийн төлөвлөгөө болон санхүүжилтийг жил бүрийн улсын төсөвт тусгахыг мөн Монгол Улсын ЗГ-т даалгасан ийм тогтоолын төсөл бас орж ирж байгаа гэсэн үг. Өөрөөр хэлэх юм бол 5 жилийн үндсэн чиглэлийн 4 дүгээр хавсралт болох улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөр дээр тусгагдаагүй төсөл, хөгжлийн төслүүдийг жилийн хөгжлийн төлөвлөгөөнүүд дээрээ тусгаад хэрэгжилтээ хангаарай гэдэг тэр зохицуулалтыг бол тогтоолын төсөл дээр бас тусгаж орж ирж байгаа.

О.Номинчимэг: Өргөдөл гомдолтой холбоотой зөвхөн ГХО-тай холбоотой л юм орж ирсэн байна гээд. Энэ 1111 төв, ЗГ-ын, Ерөнхий сайдын доор хэвээрээ байгаад байна уу? Тэгсэн мөртөө өргөдөл гомдлын асуудал хэр хэрэгжилттэй байна. Шийдвэрлэгдэж байна гэдэг Эдийн засаг хөгжлийн яамны доор Хяналтын, ЗГ-ын хяналтын газар оччихсон байх шиг байна лээ. Энэнтэй холбоотой асуудал хэн хариулах вэ?

Ахиц дэвшил л гарах уу? Гарахгүйгээр энэ асуудал дээр анхаарч ер нь энэ 5 чиглэл дээр барьж байгаа хийж байгаа ажил байна уу? Эдийн засаг, хөгжлийн яам 6 номер Сүрэнхорол дарга.

Х.Сүрэнхорол: Ерөнхий нэг тийм тойм одоо 1111 төвтэй холбоотой өргөдөл гомдлын төрийн байгууллага албан тушаалтны үйл ажиллагаатай холбоотой шийдвэр үйл ажиллагаатай холбоотой гомдлын асуудал бол 1111 төв дээр явж байгаа ЗГХЭГ-ын харьяан дотор байдаг. Мэдээж Засгийн газар дахь Хяналтын тухай хуулиараа Засгийн газар дахь хяналт хэрэгжүүлэх газар маань бас энэ төрийн байгууллага, холбогдох шийдвэр маань хууль тогтоомжид нийцэж байна уу үгүй юу гэдэг дээр бас хяналт тавиад явдаг. Нарийвчилсан тоог бол шаардлагатай бол дахиад бид нар илүү жагсаалт болгоод албан бичгээр хүргүүлэх бүрэн боломж

байгаа. 1111 төвтэй холбоотой тоон статистик мэдээлэл дээр бол одоогоор Эдийн засаг хөгжлийн яам бас тодорхой хариулж бас мэдэхгүй л байгаад байдаг юм.

О.Номинчимэг: ЗГ-ын хяналт хэрэгжүүлэх газрын Үнэлгээ мониторингийн газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэж байгаа юм байна. Баатарчулууны Золбоо энэ дээр өргөдөл гомдолтой холбоотой асуудал дээр барьж байгаа бодлого ахиц дэвшлийн талаар?

Б.Золбоо: ЗГ-ын хяналт хэрэгжүүлэх газрын хэлтэс Золбоо. Засгийн газар дахь хяналтын тухай хуулиар өргөдөл ЗГ-ын 1111 төв. Иргэд олон нийттэй харилцах төв бол ЗГ-ын хяналт хэрэгжүүлэх газарт харьяалагддаг. ЗГХЭГ-ын ЗГ-ын хуралдаан болгон буюу 7 хоног бүрийн 3 дахь өдөр 1111 төвөөс ЗГ-ын хуралдаанд өргөдөл гомдлын талаарх мэдээллийг танилцуулж байгаа.

Манай байгууллагын хувьд бол өргөдөл гомдлын нэгдсэн мэдээллийн санг үүсгээд яг явж байна. Тэгэхээр энэ ажил маань өргөдөл гомдлын нэгдсэн мэдээллийн сан үүсвэл Өргөдөл гомдлын нэгдсэн мэдээллийн сан дээр хиймэл оюун ажиллаад, аль байгууллагын очсон, аль албан тушаалтны өргөдөл илүү хоцрогдолтой эсвэл цаг хугацаандаа шийдэгдэж байгаа гэдэг мэдээллийг хүний оролцоогүйгээр гаргах нэгдсэн мэдээллийн сан бэлэн болох шатдаа явж байгаа гэсэн үг. Надад яг одоогоор байгаа тоо бол сүүлийн 7 хоногийн 1111 төвд ирсэн.

О.Номинчимэг: Баасанжаргал гишүүн тодруулъя.

Х.Баасанжаргал: Гол нь энэ нөгөө дараагийн 5 жил дээр иргэдийн өргөдөл гомдлыг шийдвэрлэх дээр ямар нэгэн үр дүн, ахиц дэвшил, шалгуур үзүүлэлт энэ дотор байхгүй байна аа. Яагаад тусгаагүй юм бэ л гэж асуугаад байгаа гэсэн үг. Энийг та хэд өөрсдөө анхаараад үзээрэй.

Хоёрдугаарт тэр боловсролын индекс дээр 0.755 байж байгаад 0.810 болно гэдэг чинь олон улсад дэлхийд манай боловсрол одоогоор манайх энэ индексээрээ хэдэд байгаад, хэдэд орно гэсэн үг юм? Ядаж нэг хэдэн байр урагшлах юм гэдгийг энэ дээр тэр талаас нь бичмээр байна. Бид нарт энэ индекс хэд байх нь бол нэг их тийм сонин биш шүү дээ тиймээ.

Хамгийн сүүлд тэр юутай холбоотой шүүхийн төсөвтэй холбоотой ямар ч байсан шүүхийн төсөв хүртээмжтэй байр байхгүй, 0 гэдгийг хүлээн зөвшөөрч байгаад баяртай байна. Энийг ахиц дэвшил болгож гаргаж хөрөнгө оруулалт нь энэ дээр нэг ч төгрөг тусгаагүй болохоор дараа жил 30-аас дээш тэрбум төгрөгийн мөнгө дахиж шүүх дээр орж ирэхгүй гэсэн үг шүү дээ. Боломжгүй болно шүү дээ. Та нар 5 жил байхгүй гээд ингээд тусгахгүй байхгүй юу. Тэгэхээр хэзээ ч энэ дээр бай.

О.Номинчимэг: 6 номер Сүрэнхорол дарга.

Х.Сүрэнхорол: Яах вэ нөгөө жилийн хөгжлийн төлөвлөгөө маань боловсруулагдаж орж ирнэ. Тэгэхээр тэрэн дээр маань тусгаад явах боломжтой. Яах вэ ер нь бол бид нар бас 5 жилийнхээ үндсэн чиглэлийг боловсруулахдаа нийт 40 төсвийн ерөнхийлөн захирагчтай хамтарч ажилласан. Тэгэхээр тухайн байгууллагуудаас маань өөрөөр хэлэх юм бол Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хуульд заасан шаардлагыг хангасан төслүүдээ өөрсдөө оруулж ирэх ёстой юм.

Тэгэхээр шүүхийн байгууллагаас бол энэнтэй холбоотой хөрөнгө оруулалтын хөтөлбөр өөрөөр хэлэх юм бол нөгөөдөх хөгжлийн төсөл ерөөсөө орж ирээгүй л гэсэн үг. Тэгэхэд одоо Эдийн засаг, хөгжлийн яам дур мэдэж өмнөөс нь хөгжлийн төсөл бас бичээд энэ жагсаалтад оруулах бас бүрэн боломж байхгүй. Өөрөөр хэлэх юм бол хуулиараа хязгаартай байгаад байгаа юм. Тэгэхээр шүүхийн байгууллагаас л энэ дээр яг хамтарч ажиллаад бас холбогдох саналуудаа яг ТЭЗҮ шаардлагаа хангасан 30 тэрбум төгрөгөөс дээш энэ төслүүдээ эрэмбэлээд оруулж ирэх ёстой.

О.Номинчимэг: 5 номер өргөдөл гомдол дээр яах вэ? ЗГХЭГ яах юм. 1111 хэрэглэх дээрээ байгаад байгаа юм байна тийм үү? Тэрний биелэлт нь яаж байна гэдэг дээр нь хяналт хэрэгжүүлэх агентлаг байгаад байгаа гэж ойлголоо.

3 номер.

Ш.Мөнхцэрэн: ЗГХЭГ-ын салбарын бодлого зохицуулалтын газрын дарга Мөнхцэрэн. 1111 Төв бол хэдийгээр ЗГХЭГ Бямбацогт сайдын төсвийн багцад явж байгаа боловч Ерөнхий сайдын ажлын албаны харьяанд шууд удирдлагаар хэрэгжиж явж байгаа. Тэгээд 1111 төв дээр бол нийт өргөдөл гомдлыг хүлээж авч байгаа хэрэгжилтийн байдалд хяналт тавих, зохион байгуулах ажлыг бол хэрэгжүүлээд түрүүн хэлсэн. ЗГ-ын хуралдаанаар тогтмол хугацаанд мэдээллийг өгч ажиллаж байгаа.

Цаашид бол би түрүүн хэлсэн. Өргөдөл гомдлын системийг боловсронгуй болгох, хиймэл оюун ухаанд суурилсан байдлаар шуурхай хариултуудыг өгдөг байх. Мэдээж өргөдөл гомдолд хуульд заасан хугацаанд өгсөн байдалд үнэлгээ хийж, хяналт тавьж, шаардлага хангаагүй холбогдох албан тушаалтанд хариуцлага тогтол тооцохыг.

Ш.Мөнхцэрэн: 3 номер нэмж хариулах уу? Шинэ тогтолцоог цааш нь боловсронгуй болгох асуудлуудаа зохион байгуулж байгаа. Хяналт тавих үйл ажиллагаа маань ЗГ-ын хяналт хэрэгжүүлэх газраас ингээд зохион байгуулагдаад явна аа.

О.Номинчимэг: Баярлалаа. Энэ иргэдийн ирж байгаа өргөдөл гомдлыг яг шат шатад нь харьяалах асуудлынхаа хүрээнд үнэхээр үр дүнтэй шийдэхгүй бол бүх асуудлыг нэгэн зэрэг юу гэдэг юм яамдад, аймаг нийслэлийн удирдлагуудад тэгээд дээр нь Улсын Их Хуралд ч гэсэн ханддаг асуудал байна. Тэр чинь аргаа бараад л тэгж байгаа шүү дээ тиймээ.

Тэгээд өмнө нь ч гэсэн энэ асуудлын талаар ЗГ-аас бас мэдээлэл сонсоход ерөөсөө 30 хоногийн дотор нэг хүн рүү шилжүүлснээ шийдсэн гээд томьёолчихдог. Ямар ч шийдэл байхгүй шийдсэн тэр хүний асуудал шийдэгддэггүй. Засгийн газар өөрсдөө 1111-ийнхээ асуудлууд нь шилжүүлснийгээ шийдсэн гээд тооцоод явчихдаг ийм асуудал байна. Тэгэхээр иргэдийнхээ асуудлыг бол шийдэж чадахгүй байна л гэж ер нь харагдаж байгаа. Тэрийгээ нэгдсэн системтэй болгоод хянаад яг энэ асуудлынх нь араас энэ чинь гүйцэтгэх эрх мэдэл хэрэгжүүлж байгаа асуудал дээр л хамгийн их өргөдөл гомдол ирж байгаа шүү дээ. Иргэдийн гарч байгаа өргөдөл гомдол бол. Тэгээд тэрийгээ нэг цэгцэлж авахгүй бол үнэхээр иргэдээ сонсдог төр байна уу үгүй юу гэдэг энэ дээр л хамгийн анхны үзүүлэлт болоод байгаа.

Тэгэхээр 5 жилийн үндсэн чиглэл дээр ч гэсэн энэ асуудлаар бас Улсын Их Хурлаас дээр гарч байгаа ажлын хэсэг дээр тодорхой саналууд гарна гэж харж байгаа.

Гишүүд асуулт асууж, үг хэлж дууслаа.

Улсын Их Хурлын гишүүдээс Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.14 дүгээр зүйлд заасны дагуу зарчмын зөрүүтэй санал Байнгын хорооны ажлын албанд ирээгүй болно оо.

Монгол Улсыг 2026-аас 2030 онд хөгжүүлэх 5 жилийн үндсэн чиглэл батлах тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийн анхны хэлэлцүүлгийг явуулж дууслаа.

Тогтоолын төслийн анхны хэлэлцүүлгийг явуулсан талаарх Өргөдлийн байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Эдийн засгийн байнгын хороонд байгаа. Лувсанжамц гишүүн Эдийн засгийн байнгын хороонд хуралдаанд уншиж танилцуулна.

Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх асуудал дууссан тул өнөөдрийн хуралдааныг хаасныг мэдэгдье ээ. Гишүүддээ баярлалаа.

13.02 цаг

ДУУНЫ БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ
ТЭМДЭГЛЭЛ БУУЛГАЖ, ХЯНАСАН: ШИНЖЭЭЧ

П.МЯДАГМАА